ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН 2025



СКАЙ ХАЙПЕРМАРКЕТ ХХК



ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

“Скай Хайпермаркет” ХХК нь Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын гүйцэтгэлийн талаарх мэдээллээ олон нийтэд ил тод хүргэх зорилгоор тогтвортой байдлын тайлангаа гурав дахь жилдээ танилцуулж байна. Тайлангийн зорилго нь компанийн тогтвортой байдлын стратегийг хэрэгжүүлэх замаар нийгэм, эдийн засагт бодит хэрэгцээтэй, урт хугацааны үнэ цэнийг хэрхэн бүтээж буйг оролцогч талуудад ойлгомжтой хүргэж, түншлэлийг хөгжүүлэхэд оршино. Энэхүү тайланд 2025 онд оролцогч талуудтай хийсэн хамтын ажиллагааны бодлого, үйл ажиллагаа, хүрсэн үр дүнд төвлөрсөн болно.

Тайлант хугацаа, давтамж

Тайлангийн мэдээлэл нь 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх нэг жилийн хугацаанд хамаарна. Өмнөх тогтвортой байдлын тайланг 2025 онд нийтэлсэн бөгөөд 2024 оны мэдээллийг хамарсан болно.

Нийтэлсэн огноо: 2026 оны 08 дугаар сар

Тайлагнах зарчим

Энэхүү тайланг боловсруулахдаа тайлагналын олон улсын нийтлэг зарчим, арга зүйг харгалзан үзэж, БНСУ-ын “Имарт” компанийн тогтвортой байдлын тайлангийн загвар, арга зүйг жишээ болгон ашигласан болно.

Холбоо барих

Төв оффис: Имарт Чингис салбар, 7 давхар, Токиогийн гудамж-23, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар-13381, Монгол улс

И-мэйл: info@e-mart.mn

Утас: 976 - 7611 0101



ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

БИДНИЙ ТУХАЙ
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ 5
Компанийн танилцуулга 6
Алсын хараа, үнэт зүйлс 7
Компанийн уйл ажиллагааны танилцуулга 8
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ
Тогтвортой байдлын стратеги 10
Материаллаг байдлын үнэлгээ 11
Оролцогч талуудтай харилцах суваг 12
Тогтвортой хөгжлийн зорилготой уялдах нь 13
БАЙГАЛЬ ОРЧИН
Байгаль орчны менежмент 15
Эрчим хүчний менежмент 16
Хог хаягдлын менежмент 17
Ногоон байгууламж ба ойжуулалт 18
Нөөцийн хэмнэлт ба цахимжуулалт 19
Цахим худалдаа ба ногоон тээвэр 20
НИЙГЭМ - ХАРИУЦЛАГАТАЙ ХУДАЛДАА БА ҮЙЛЧИЛГЭЭ
Хүнсний чанар ба аюулгүй байдал 22
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) 23
Харилцагчийн үйлчилгээ, санал гомдлын удирдлага 24
Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ 25
НИЙГЭМ - ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ
Хүний нөөцийн бодлого 29
Олон талт, хүртээмжтэй ажлын байр 30
Ажиллах орчин, ажилтны сайн сайхан байдал 31
Сургалт ба ажилтны хөгжлийн хөтөлбөр 32
ЗАСАГЛАЛ
Төлөөлөн удирдах зөвлөл 34
Гүйцэтгэх удирдлагын бүтэц 35
Хариуцлагатай манлайлал 36
ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА (CSR)
Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа (CSR) 38
ХАВСРАЛТ
2025 оны онцлох амжилтууд 42
Гэрчилгээ, баталгаажуулалт 43
Гишүүнчлэл болон шагнал 44
Гишүүн болон “Санамж бичиг” байгуулсан байгууллагууд 45



1 БИДНИЙ ТУХАЙ

Монгол хүн Та 100 наслаг...

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
Компанийн танилцуулга
Алсын хараа, үнэт зүйлс
Үйл ажиллагааны танилцуулга

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм харилцагчид, хэрэглэгчид, ажилтнууд болон хамтран ажиллагч түншүүд ээ

“Скай Хайпермаркет” ХХК-ийн 2025 оны Тогтвортой байдлын тайланг гурав дахь жилдээ танилцуулж байгаадаа баяртай байна. Энэ онд бид Улаанбаатар хотын зүүн бүсийн хэрэглэгчдэдээ илүү ойртон Имартын 6 дахь салбараа амжилттай нээлээ. Энэхүү амжилт нь ажилтнуудын маань хичээл зүтгэл, хамтрагч байгууллагуудын тогтвортой хамтын ажиллагаа, хэрэглэгч болон хөрөнгө оруулагчдын тууштай дэмжлэгийн үр дүн юм.

Бид эдийн засгийн өсөлтийг байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) зарчимтай уялдуулан хөгжүүлж, хариуцлагатай, тогтвортой бизнесийг бий болгохыг зорин ажиллаж байна.

Тайлант онд бид үйл ажиллагааны цахимжилтийг нэмэгдүүлж, цаасан хэрэглээг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг байгаль орчинд чиглэсэн ажлуудаа үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. Мөн ажилтны сэтгэл ханамжтай, тогтвортой ажиллах орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллаа. Ажилтнуудын цалин хөлсийг дунджаар 40 хувиар нэмэгдүүлж, ажлын орчин болон сургалт хөгжлийн боломжийг сайжруулснаар ажилтны сэтгэл ханамж өмнөх оноос 8 хувиар өссөн байна.

Компанийн засаглал, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг төлөвшүүлэх хүрээнд компанийн нийт ажилтанд мөрдүүлэх “Ёс зүйн 12 зарчим”, мөн хамтран ажиллагч харилцагч, нийлүүлэгч, бизнесийн түншүүдэд баримтлах “Бизнесийн түншийн ёс зүйн зарчим”-ыг шинэчлэн батлаж хэрэгжүүлж эхэллээ.

2026 онд бид чанартай бүтээгдэхүүнийг хүртээмжтэй үнээр хүргэх зорилгоор “No Brand” дэлгүүрүүдийг Монгол Улсад нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлын удирдлагын ISO 22000 стандартыг үе шаттайгаар хэрэгжүүлэхийн зэрэгцээ үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулан бизнесийн өсөлтөө дараагийн түвшинд хүргэхээр ажиллаж байна.

Ирэх онд Имартын 10 жилийн ойгоо угтан бид ёс зүйтэй, хариуцлагатай менежментийн тогтолцоогоор худалдааны салбарын манлайлагч байж, оролцогч талуудтайгаа хамтран Монгол хүний эрүүл, чанартай амьдралд хувь нэмрээ оруулан, “Монгол хүн Та 100 наслаг” эрхэм зорилгоо тууштай хэрэгжүүлэх болно.

Хүндэтгэсэн,
Л. Жавзмаа
Гүйцэтгэх захирал,
Скай Хайпермаркет ХХК

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Компанийн нэр	СКАЙ ХАЙПЕРМАКЕТ ХХК
Хаяг	Имарт Чингис салбар, 7 давхар, Токиогийн гудамж-23, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар-13381, Монгол улс
Хуулийн этгээдийн хэлбэр	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
Үүсгэн байгуулагдсан огноо	2014 оны 3 дугаар сарын 7-ны өдөр
Гүйцэтгэх захирал	Л.Жавзмаа
Үйл ажиллагааны чиглэл	Хүнс болон барааны жижиглэн бөөний худалдаа Гадаад худалдаа Өөрийн болон лизингийн үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа Сургалтын үйл ажиллагаа
Нийт ажилтны тоо	1500+
Цахим хуудас	www.e-mart.mn
Тайлангийн хамрах хугацаа	2025.01.01~2025.12.31

ИМАРТ МОНГОЛ - “СКАЙ ХАЙПЕРМАРКЕТ” ХХК

“Скай Хайпермаркет” ХХК нь 2014 онд “Алтай Холдинг” группийн охин компани “Скай Трейдинг” ХХК (90%) болон БНСУ-ын “Имарт” компани (10%)–ийн хамтарсан хөрөнгө оруулалтаар байгуулагдсан. Улмаар ‘Скай трейдинг” ХХК-ийн жижиглэн худалдааны туршлага дээр үндэслэн 2016 онд “Имарт Чингис” нэртэй анхны франчайз салбараа нээн олон улсын худалдаа, үйлчилгээний стандарт, туршлагыг Монголын зах зээлд нэвтрүүлсэн.

Өнөөдөр “Скай Хайпермаркет” ХХК нь Улаанбаатар хотод 6 салбар дэлгүүр, Нэгдсэн түгээлтийн төв, Гидропоник хүлэмж, Хүнс хөгжүүлэлт, судалгааны төв, онлайн болон байгууллагын борлуулалтын платформоор дамжуулан 1,500 гаруй ажилтны хамтаар өдөр бүр 20,000 гаруй үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд хүрч үйлчилж байна

АЛТАЙ ХОЛДИНГ ХХК

“Алтай Холдинг” ХХК нь 1991 онд “Алтай Трейдинг” нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, 2005 оноос холдинг бүтцэд шилжин худалдаа үйлдвэрлэл, зочид буудал, мэдээллийн технологи, боловсрол, хэвлэл мэдээллэл зэрэг олон салбарт үйл ажиллагаа явуулж буй үндэсний тэргүүлэгч компани юм. Өнөөдөр тус компани нь “Чингисхаан цогцолбор” ХХК; “Алтай кашмир” ХХК; “Скай Трэйдинг” ХХК; “Юнайтед Бродкастинг Корпорэйшн” (Star HD TV); “Дата Кейр” ХХК зэрэг охин компаниудаараа дамжуулан олон салбарт тэргүүлж, Монгол Улсын эдийн засаг, бизнесийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсаар байна.

СТРАТЕГИЙН ТҮНШ – ИМАРТ (БНСУ)

“Имарт” нь 1993 онд БНСУ-ын Сөүл хотод анхны хайпермаркетыг нээж, хямд үнийн томоохон худалдаа, үйлчилгээний төвийг анхлан нэвтрүүлсэн компани юм. Өдгөө “Имарт” компани нь БНСУ-ын жижиглэн худалдааны салбарт тэргүүлэгч болтлоо өргөжиж цаашлаад, АНУ болон Азийн бүс нутагт экспорт болон франчайзын бизнесийн загвараар дамжуулан үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд Вьетнам, Монголд “Emart” дэлгүүрүүд, Лаос болон Филиппинд “No Brand” дэлгүүрүүдийг ажиллуулж, 23 улсын зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлж байна.





АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛ

АЛСЫН ХАРАА
Өргөн сонголт хэзээд, хаана ч

ЭРХЭМ ЗОРИЛГО
Сайн чанарын барааг үргэлж хямд үнээр нийлүүлж, үйчлүүлэгчдийг аз жаргалтай байлгах

УРИА ҮГ:
Монгол хүн Та 100 наслаг...

ҮНЭТ ЗҮЙЛС
- ✓ Ажилтан
- ✓ Үйлчлүүлэгч
- ✓ Хамтрагч байгууллага
- ✓ Эх орон Нийгэм
- ✓ Хөрөнгө оруулагч

Бид үргэлж таны дэргэд!

Бид Танд олон төрлийн бараанаас сонголтоо хийхийг санал болгож өдөр тутмын бүхий л хэрэгцээг Тань салбар дэлгүүрүүдээрээ хүргэхээр зорьж ажиллах болно.

Бид таны амьдралыг аз жаргалаар дүүрэн байлгана!

Бидний үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнээс хүсэн хүлээж буй хүлээлтийг Тань соргогоор мэдэрч, бараа бүтээгдэхүүнээ хэрэгтэй цаг, шаардлагатай газарт Тань байлгахыг үргэлж эрмэлзэн ажиллана.

Бид хямд үнийг санал болгодог!

Бид худалдаалж буй сайн чанарын бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээндээ хямд үнийг санал болгодог. Бараа бүтээгдэхүүний үнийг боломжит хэмжээнд хүртэл буулгахыг өдөр бүрийн зорилгоо болгон ажиллана.

Иргэдтэйгээ хамтдаа хөгжинө!

Бид нийгмийн хариуцлагаа биелүүлэхийн төлөө бололцоотой бүхнийг хийдэг ба дотоодын хэрэглэгчдээ дээдлэх нь бидний ажлын алтан дүрэм юм.

АЖИЛТНАА ХҮНДЭТГЭНЭ
Ажилтан бол Имартын үнэ цэнтэй хөрөнгө мөн. Тиймээс Имартад ажиллаж байгаа бүх ажилтныг хүндэтгэж, хөгжин дэвших бүхий л боломжоор хангана.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧЭЭ ХҮНДЭТГЭНЭ
Үйлчлүүлэгч бол бидний оршин тогтнох үндэс. Имарт үйлчлүүлэгчдэдээ үргэлж сайн чанарын барааг хямд үнээр худалдаалахын тулд компанийн хэлтэс нэгж, ажилтан бүр бүх хүч чадлаа дайчлан ажиллана.

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГАА ХҮНДЭТГЭНЭ
Имарт нь хамтрагч байгууллагатайгаа харилцан итгэлцэл дээр тулгуурлан хөгжин дэвшихийн төлөө хамтран ажиллана.

ЭХ ОРОН, НИЙГМИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ХАРИУЦЛАГАА ХҮНДЭТГЭНЭ
Имарт нь нийгмийн нэг бүрэлдэхүүн хэсэг тул хууль дүрмийг чандлан мөрдөж, тогтвортой өсөлтөөр дамжуулан түүний хөгжилд хувь нэмэр оруулж хамтдаа өсөн дэвжихийг эрмэлзэнэ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧАА ХҮНДЭТГЭНЭ
Хөрөнгө оруулагч нь Имартын гол түшиг тулгуур юм. Үр ашигтай менежментээр компанийн үнэ цэнийг үргэлж нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

ИМАРТ ЧИНГИС

2016.07
Монгол дахь хамгийн анхны Имарт хайпермаркетийн сүлжээ дэлгүүр Имарт Чингис салбар нээгдэв.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг-13381, 3-р хороо, Токиогийн гудамж-23



ИМАРТ ХОРООЛОЛ

2017.09
Имарт Хороолол буюу 2 дахь салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг-16091, 13-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө.



ИМАРТ ХАН-УУЛ

2019.09
Имарт Хан-Уул буюу 3 дахь салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17011, 15-р хороо, Их Монгол гудамж-71



ТҮГЭЭЛТИЙН ТӨВ


2020.09
Имарт Түгээлтийн төвийг ашиглалтад оруулав.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17070, 3-р хороо, Ноолуурын -43



EMARTMALL.MN

2020.01
Имарт Online Shopping Mall үйл ажиллагаагаа эхлэв



ИМАРТ БАЯНГОЛ

2023.09
Имарт Баянгол буюу 4 дэх салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг-16080, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө



ГИДРОПОНИК ТӨСӨЛ

2022.10
Хөрс ашиглахгүйгээр ургамлыг шим тэжээлээр баялаг усан уусмалд ургуулах дэвшилтэт технологи бүхий гидропоник төслийн навчит ногоог борлуулж эхлэв.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17070, 3-р хороо, Ноолуурын-43



ХҮНС ХӨГЖҮҮЛЭЛТ, СУДАЛГААНЫ ТӨВ

2023.12
“Хүнс хөгжүүлэлт, судалгааны төв”-ийг байгуулж, 2024 оноос албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлэв.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ноолуурын гудамж-43, 17070.



ИМАРТ БИЗНЕС КЛУБ

Жижиглэнгийн худалдаанаас гадна аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан үйл ажиллагааг 2018 оноос явуулж ирсэн бөгөөд **2024 онд** Имартын Бизнес Клуб болон тэллээ.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17070, 3-р хороо, Ноолуурын -43


businessclub.e-mart.mn



ИМАРТ ДРАГОН

2024.12
Имарт Драгон буюу 5 дах салбараа нээв.


Хаяг: Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 29-р хороо, Москва хороолол -18072 Энхтайваны өргөн чөлөө



ТӨВ ОФФИС

2025 онд Имарт Чингис салбарын 7 давхрыг шинэчлэн тохижуулж, бүтээмж, тав тухыг дэмжсэн орчин үеийн ажлын орчныг бүрдүүлэн ашиглалтад оруулав.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Токиогийн гудамж-23, Имарт Чингис салбар 7-р давхар



ИМАРТ ТЭНГЭР

2025.12
Имарт Тэнгэр буюу 6 дах салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Улаанхуаран/13302, Энхтайваны өргөн чөлөө





2 ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Тогтвортой байдлын стратеги
Материаллаг байдлын үнэлгээ
Оролцогч талуудтай харилцах суваг
Тогтвортой хөгжлийн зорилготой уялдах нь

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

“Скай Хайпермаркет” ХХК нь байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмуудыг бизнесийн стратеги, өдөр тутмын үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэгтгэн хэрэгжүүлж тогтвортой хөгжил болон нийгмийн хариуцлагыг бизнесийн үйл ажиллагааны салшгүй хэсэг гэж үздэг. Бид эдийн засгийн үр өгөөжийг бий болгохын зэрэгцээ нийгэм, хэрэглэгч, ажилтан, нийлүүлэгч, түнш байгууллагууд болон бусад оролцогч талуудад урт хугацааны эерэг нөлөө бий болгоход чиглэн ажиллаж байна.


2023 онд бид “Тогтвортой Имарт” зорилтын хүрээнд анх удаа тогтвортой хөгжлийн үндсэн чиглэлүүдийг (E – Байгаль орчин, S – Нийгэм, G – Засаглал) тодорхойлон, сайн туршлагыг системчлэх, нэршүүлэх, хэмжих зэргээр байгууллагынхаа бүх түвшинд тогтвортой байдлын суурь ойлголтыг нэвтрүүлж эхэлсэн.

2024 онд “Эерэг Имарт” зорилтын хүрээнд ажилтнуудын сайн сайхан байдал, сургалт хөгжлийн хөтөлбөрүүдийг өргөжүүлэхийн зэрэгцээ эрчим хүчний үр ашигтай шийдлүүдийг нэвтрүүлж, хог хаягдлын ангилан ялгалт, дахин ашиглалт болон дахин боловсруулалтын үйл ажиллагааг сайжруулан бодит эерэг нөлөөллийг бий болгоход анхааран ажилласан.

2025 онд “Маргаашийн Имарт” зорилтын хүрээнд компанийн урт хугацааны тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэхээр байгаль орчин, нийгэм, бизнесийн ёс зүйн шаардлагыг гэрээний хэрэгжилтэд тусгаж эхэллээ. Мөн *“Ажилтны ёс зүйн 12 зарчим”, хамтран ажиллагч харилцагч, нийлүүлэгч, бизнесийн түншүүдэд баримтлах “Бизнесийн түншийн ёс зүйн зарчим”-ыг шинэчлэн батлаж хэрэгжүүлж эхэлсэн.* Ингэснээр ханган нийлүүлэгч, харилцагч, бизнесийн түншүүдтэй хамтран хариуцлагатай ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх суурийг тавилаа.

Бид тогтвортой байдлын стратегийг компанийн урт хугацааны төлөвлөгөө, бизнесийн зорилготой уялдуулан дараалсан үе шат бүхий тодорхой сэдвийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.


Бидний хувьд тогтвортой байдлын зорилго нь хүн бүрийн идэвхтэй оролцоо, эерэг хандлага, бодит үйлдлээр илэрдэг байгууллагын соёл, хамтын хариуцлага болсон төлөвшүүлэх явдал юм.



МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

“Скай Хайпермаркет” ХХК нь тогтвортой байдлын стратеги, зорилтыг тодорхойлохдоо компанийн оролцогч талуудад хамгийн чухал хамааралтай , урт хугацаанд үнэ цэнийг бий болгох чадварт бодитойгоор нөлөөлөх асуудлуудад үндэслэж төлөвлөдөг.

Бид “Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК-ийн БОНЗ-ын нөлөөллийн 14 үндсэн хүчин зүйл болон “Скай Хайпермаркет” ХХК-ийн зорилтуудын хүрээнд боловсруулсан материаллаг байдлын үнэлгээний матрицыг суурь болгон ашиглаж байна. Цаашид бизнесийн орчин, оролцогч талуудын хүлээлтэд нийцүүлэн материаллаг байдлын үнэлгээг дахин тодорхойлж ажиллана.



	Хүчин зүйлс	БОНЗ хүрээ	Товчлол	Материаллаг байдал
1	Хөдөлмөрийн харилцаа	Нийгэм	(LR)	*Double / Impact + Financial/*
2	Хүнсний аюулгүй байдал	Нийгэм	(FS)	*Double / Impact + Financial/*
3	Хүний эрх	Нийгэм	(HR)	*Impact*
4	Тогтвортой худалдан авалт	Нийгэм	(SP)	*Impact*
5	Нийгмийн хариуцлага	Нийгэм	(CSR)	*Impact*
6	Хог хаягдал	Байгаль орчин	(WD)	*Impact*
7	ХАБЭА	Нийгэм	(OHS)	*Double / Impact + Financial/*
8	Усны хэрэглээ	Байгаль орчин	(H2O)	*Impact*
9	Эрчим хүчний хэрэглээ	Байгаль орчин	(PC)	*Financial*
10	Мэдээллийн ил тод байдал	Засаглал	(IT)	*Financial*
11	Ялгаатай байдал, оролцоо	Засаглал	(DEI)	*Impact*
12	Ёс зүй	Засаглал	(BE)	*Impact*
13	Бизнесийн тасралтгүй байдал	Засаглал	(BC)	*Financial*
14	Хүлэмжийн хийн ялгарал	Байгаль орчин	(CO)	*Impact*

**Тайлбар*

Хос/double материаллаг байдал: Асуудал нь компанийн үйл ажиллагаанд болон оролцогч талуудын хувьд зэрэг өндөр ач холбогдолтой.

Нөлөөллийн материалаг байдал: Асуудал нь оролцогч талуудын хүлээлт, сонирхолд өндөр ач холбогдолтой.

Санхүүгийн материаллаг байдал: Асуудал нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд өндөр ач холбогдолтой.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ СУВАГ

“Скай Хайпермаркет” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ оролцогч талуудын оролцоог бодитоор хангаж, харилцан итгэлцэлд суурилсан тогтвортой хамтын харилцааг бий болгохыг эрхэм зорилгоо болгон ажилладаг. Бид хэрэглэгчид, ажилтнууд, төрийн байгууллагууд болон стратегийн түншүүдтэй үйл ажиллагааныхаа бүх түвшинд нээлттэй, ил тод, тогтвортой харилцахыг эрмэлздэг. Тэдний хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн үр дүнтэй сувгаар мэдээлэл солилцож, хамтын үнэ цэнийг бүтээх нь бидний үндсэн зарчмуудын нэг юм.

Үйлчлүүлэгч	Ажилтан	Нийлүүлэгч	Олон нийт	Төрийн байгууллагууд	Санхүүгийн байгууллагууд	Хувьцаа эзэмшигч Хөрөнгө оруулагч	БНСУ-ын Имарт компани	Түнш байгууллагууд ТББ, холбоо
ХАМРАХ ГОЛ АСУУДАЛ								
Тогтвортой бүтээгдэхүүн, үнэ цэн, сэтгэл ханамж, эерэг үйлчилгээний мэдрэмж	Цалин, бүтээмж, сайн сайхан байдал, ажлын орчин, карьер өсөлт	Түншлэл, шударга худалдан авалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт	Оролцооны төсөл, байгаль орчны санаачилга, хамтын үнэ цэн	Хууль тогтоомжийн нийцлийн хяналт, нээлттэй тайлагнал	Санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн өсөлт	Стратегийн хяналт, хөрөнгө оруулалт, тогтвортой байдал	Франчайз хяналт, стратеги	Хамтран хэрэгжүүлэх төсөл, оролцооны санаачилга, олон талт хамтын ажиллагаа
ХАРИЛЦАХ СУВАГ								
Хэрэглэгчийн үйлчилгээний төв, Үйлчлүүлэгч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, Имарт апп, веб, албан ёсны нийгмийн сүлжээ (Facebook, YouTube, Instagram, TikTok), цахим шуудан, санал хүсэлтийн хайрцаг, цахилгаан холбоо	Дотоод мэдээллийн сувгууд, бүх нийтийн хурал, ажилтны сэтгэл ханамжийн судалгаа, цахим санал, асуулга, ажилтны дуу хоолой, олон нийтийн үйл ажиллагаа, сургалт хэлэлцүүлэг	B2B уулзалт, гэрээ, хамтарсан шийдэл, Имарт апп, платформ (Urtu.mn, business-club.e-mart.mn), судалгаа, хамтын ажиллагааны уулзалт	Имарт апп, веб, албан ёсны нийгмийн сүлжээ (Facebook, YouTube, Instagram, TikTok), Хэрэглэгчийн үйлчилгээний төв, цахим шуудан цахилгаан холбоо	Олон нийтийн уулзалт, санал асуулга, сургалт, төсөл мэлээллийн хөтөлбөрүүд, хэлэлцүүлэг, албан бичиг, цахим шуудан, аудит, тайлан, хяналт	Албан бичиг, аудит, уулзалт, цахим шуудан, цахилгаан холбоо	ТУЗ, хөрөнгө оруулагчдын хурал	ТУЗ-ийн хурал цахим хурал, тайлан, Франчайз сургалт, шууд харилцаа	Меморандум, сургалт, төсөл, нөлөөллийн судалгаа, орон нутгийн хэлэлцүүлэг
МОНИТОРИНГ АРГАЧЛАЛ								
NPS оноо, сэтгэл ханамжийн судалгаа, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн санал асуулгын тайлан	Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа, 360^0 үнэлгээ, сар бүрийн гүйцэтгэлийн үнэлгээ	Нийлүүлэгчийн үнэлгээний систем, гэрээний гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ	Оршин суугчдын санал асуулга, төсөл бүрийн нөлөөллийн тайлан	Хяналт, аудитын дүгнэлт, тайлангийн батламж, хуулийн нийцэл	Зээлийн эрсдлийн үнэлгээ, БОНЗ-н мэдээлэлд суурилсан дотоод үнэлгээ, санхүүгийн хяналт, тайлагнал	ТУЗ-ийн шийдвэр хэрэгжилтийн хяналт	Франчайз стандартын үнэлгээ	Төсөл хэрэгжилтийн үр дүнгийн дүгнэлт, хамтрагч байгууллагын үнэлгээ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДАХ НЬ

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд бүх оролцогч талуудын үүрэг амлалт, хүчин чармайлт чухал бөгөөд Скай Хайпермаркет ХХК нь бизнесийн стратеги, бүтээгдэхүүн, үйлчилгээ, БОНЗ-ын үйл ажиллагаагаараа дамжуулан Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд бодит хувь нэмэр оруулж байна. Цаашид БОНЗ-ын гүйцэтгэлээ улам сайжруулж, үзүүлэх эерэг нөлөөллөө тасралтгүй сайжруулах болно.



Өлсгөлөнг зогсоох

Чанартай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх

Хүнс хөгжүүлэлт, судалгааны төв болон салбар дэлгүүрүүдээр дамжуулан аюулгүй, чанартай хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна.



Эрүүл мэндийг дэмжих

Эрүүл мэндийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх

2025 онд нийт **500+** ажилтанд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн сайн дурын даатгал болон ажилтны сайн сайхан байдлыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.



Чанартай боловсролыг дэмжих

Сургалт зохион байгуулах

2025 онд ажилтнуудаа тогтмол сургалтад хамруулж, **93** ажилтан гадаад сургалтад, нийт **7** ажилтныг дээд болон ахисан түвшний боловсрол эзэмшүүлэхээр их, дээд сургуульд элсүүлсэн.



Жендерийн тэгш байдлыг хангах

Эмэгтэй ажилтнуудаа өргөжүүлэн дэмжих

Нийт ажиллах хүчний төлөөллийн **64.3%** удирдлагын түвшинд **60%**. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн **25%**-ийг эмэгтэй ажилтан бүрдүүлж байна. Мөн “Women Owned” санаачилгаар дамжуулан эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжиж ажилласан.



Баталгаат усан хангамж, ус ариун цэврийн байгууламжийг хангах

Ус хэмнэх шинэчлэл

Усны нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжин ажилласнаар, усны зарцуулалт өмнөх оноос **6.4** хувиар буурсан.



Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх

Эрчим хүчний хэмнэлтийн технологи ашиглах

Салбаруудын дээвэрт нарны эрчим хүчний системийг үе шаттайгаар суурилуулан цаашид хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.



Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих

Ажлын байр нэмэгдүүлэх

2025 онд нийт **1503** ажилтныг ажлын байраар хангаж, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй **41** ажилтан, өндөр насны тэтгэвэрт гарсан **86** ажилтан байна.



Инноваци ба дэд бүтцийг хөгжүүлэх

Шинэ технологи нэвтрүүлэх

“Self Checkout” болон “Scan & Go” зэрэг шийдлүүдийг нэвтрүүлснээр худалдан авалтыг илүү хялбар, хурдан, ухаалаг болголоо.



Тэгш бус байдлыг бууруулах

Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг дэмжих

Нийт борлуулалтын **77.2** хувийг дотоодын худалдан авалт бүрдүүлж байна.



Ээлтэй хот, ногоон орчныг дэмжих

Ногоон байгууламж нэмэгдүүлэх

Дэлгүүрийн гадна зүлэгжүүлсэн талбайн **20%**-ийг ногоон байгууламж эзэлдэг.



Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл

Хог хаягдал багасгах

Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, ханган нийлүүлэгчдэд байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагыг нэвтрүүлэн ажиллаж байна.



Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах

Карбон хийн ялгарлыг бууруулах

2023 оноос эхлэн цахилгаан автомашиныг цахим худалдааны түгээлтийн үйл ажиллагаандаа ашиглаж, 2025 онд **22,930** ногоон хүргэлт хийгдсэн.



Хуурай газрын экосистемийг хамгаалах

Мод тарих аян

2018 оноос хойш мод тарих болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төслүүдийг жил бүр тогтмол хэрэгжүүлж, 2025 онд **1,380** ширхэг мод тарьсан .



Энх тайван, шударга ёсыг цогцлоох

Ил тод, ёс зүйт засаглалыг төлөвшүүлэх

Ажилтны ёс зүйн **12** зарчим болон Бизнесийн түншийн ёс зүйн зарчмаар дамжуулан хүний эрх, хууль тогтоомжийг дээдлэн авлига хээл хахуулиас ангид байх зарчимтай ажиллаж байна.



3 БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчны менежмент
Эрчим хүчний менежмент
Хог хаягдлын менежмент
Ногоон байгууламж ба ойжуулалт
Нөөцийн хэмнэлт ба цахимжуулалт
Цахим худалдаа ба ногоон тээвэр

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

“Скай Хайпермаркет” ХХК нь үйл ажиллагааныхаа байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгийн бага түвшинд барихыг эрмэлзэн ажилладаг. Энэ хүрээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, цахилгааны хэрэглээг багасгах, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэвтрүүлэх, цаасны хэрэглээг багасгах чиглэлээр анхаарч ажиллаж байна.

Бид 2024 оноос олон улсын ISO 14001:2015 (Байгаль орчны менежментийн тогтолцоо) стандартыг нэвтрүүлж, байгууллагын түвшинд байгаль орчны эрсдэл, нөлөөллийг тогтоох, хянах, бууруулах үйл явцыг системтэйгээр удирдан ажиллаж байна. Энэ хүрээнд ус, агаар, хөрсний чанарт тогтмол хяналт-шинжилгээ хийж, хууль тогтоомж, холбогдох стандартын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Цаашид байгаль орчны менежментийн тогтолцоог байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтвортой төлөвшүүлж, тойрог эдийн засгийн зарчмуудыг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, оролцогч талуудын байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлд зорин ажиллаж байна.

2025 онд

81,557 m^3

⬇6.4%

Өмнөх онтой харьцуулахад

УСНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

“Скай Хайпермаркет” ХХК-ийн бүх салбар, обьектууд нь Улаанбаатар хотын төвлөрсөн бохир усны сүлжээнд холбогдсон бөгөөд усны чанар болон бохир усны менежментийг улирал тутам мэргэжлийн байгууллагаар шинжлүүлж, үнэлгээ хийлгэж байна. Мөн усны худаг болон бохирын системийг жилд хоёр удаа, хавар болон намрын улиралд гүн цэвэрлэгээнд хамруулдаг. Сүүлийн жилүүдэд салбаруудын тоо нэмэгдэж усны хэрэглээ нэмэгдсэн ч, компанийн зүгээс усны үр ашигтай хэрэглээг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр усны зарцуулалт өмнөх оноос 6.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэрэгжүүлсэн гол арга хэмжээнүүд:

- Мэдрэгчтэй угаалтуур, суултуур суурилуулах
- Дулааны узелийн тоног төхөөрмжийг автоматжуулах
- Агаажуулалтын усан койлуудыг шинэчилж усны алдагдлыг бууруулах
- Гидропоник хүлэмжийн системд шинэчлэл хийж, системийн усыг хагас жилд нэг удаа солих боломжтой болгосон. Гарсан хаягдал усыг гадна талбайн мод услахад ашигласнаар дахин ашиглалтын хувь нэмэгдсэн.

УСНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ НЭГДСЭН ХҮСНЭГТ

Усны хэрэглээ	Үзүүлэлт, хэмжих нэгж (тн)	2022	60,237
		2023	68,359
		2024	87,106
		2025	**81,557**

НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

Компанийн үйл ажиллагааны өсөлттэй холбоотой ажиллах орчны багтаамжийг нэмэгдүүлэх хэрэгцээ үүссэн. Үүнтэй холбоотойгоор бид шинэ газар эзэмших бус, одоо ашиглаж буй нөөц газраа үр ашигтай ашиглахаар 2025 онд Төв оффисыг “Имарт Чингис” салбарын барилгын дээд хэсэгт нэмэлт 7 давхар болгон ашиглалтанд оруулаа.

Энэхүү шийдэл нь:

- Шинээр газар ашиглах хэрэгцээг бууруулах
- Хөрсний хэт ашиглалт, бохирдлоос сэргийлэх
- Газрын нөөцийг дахин ашиглан дотоод орчны багтаамжийг нэмэгдүүлэх
- Барилгын зардлыг оновчтой зохион байгуулах
- Үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах ач холбогдолтой.



ЭРЧИМ ХҮЧНИЙ МЕНЕЖМЕНТ

Эрчим хүчний үр ашгийг сайжруулах арга хэмжээ: Эрчим хүчний хэрэглээг бууруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тайлант онд хэд хэдэн салбар дэлгүүрүүд болон төв оффисын гэрэлтүүлгийн системийг автоматжууллаа. Мөн гэрэлтүүлгийг цагийн хуваарийн дагуу удирдах, Чингис салбарын халаалт, агааржуулалтын системийн автоматжуулалт зэрэг шийдлүүдийг нэвтрүүллээ. Шинэ оффисын өргөтгөлд байгалийн гэрэлтүүлэг, агаарын солилцоог нэмэгдүүлэх автомат дээврийн системийг 100м² тутамд төлөвлөж, оффисын дотоод орчинд нарны гэрэл болон байгалийн агааржуулалтыг үр ашигтай нэвтрүүлэх шийдлийг хэрэгжүүлсэн.Түүнчлэн төв оффисын гэрэлтүүлгийг өдрийн цайны цаг болон ажлын бус цагаар хэсэгчлэн унтраах тохиргоог нэвтрүүлснээр эрчим хүчний шаардлагагүй хэрэглээг бууруулахын зэрэгцээ ажилтнуудын амралт, тав тухтай орчныг дэмжих нөхцөлийг бүрдүүлэв.

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ: Бид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд “Имарт Баянгол” салбарын дээвэрт 35кВт хүчин чадалтай онгрид төрлийн нарны эрчим хүчний системийг 2024 оноос ашиглаж эхэлсэн. Тус систем нь худалдааны төвийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээний тодорхой хэсгийг хангахын зэрэгцээ илүүдэл эрчим хүчийг төвийн сүлжээнд нийлүүлж байна. Дараагийн шатанд Чингис салбарын дээвэр дээр 250кВт хүчин чадалтай нарны цахилгаан үүсгүүр суурилуулахаар төлөвлөж байна. Төслийг хэрэгжүүлсэнээр жилд ойролцоогоор 394,600кВт. цаг эрчим хүчийг хэмнэх боломжтой.

Улс	Хамрах хүрээ	Эх үүсвэр	Нэгж	2024 он	2025 он
Монгол	Имарт 5 салбар дэлгүүр, түгээлтийн төв	Цахилгаан	кВт.цаг	20 498 288	21 121 604
		Дулаан	гж	41 925	42 904
		Газ	*кг*	103 088	105 424
		Дизель	л	16 089	11 702

Имарт 5 салбар дэлгүүр, Түгээлтийн төв	Хүлэмжийн хийн ялгаруулалт /тонн CO_2eq/		
	Шууд ялгаруулалт (Хамрах хүрээ 1)	**Шууд бус ялгаруулалт (Хамрах хүрээ 2)**	**Нийт**
2024 он	*392.43*	*27,028.61*	*27,421*
2025 он	*381.06*	*27,989.76*	*28,371*
Өөрчлөлт (2024-2025)	*↓2.90%*	*3.56%↑*	*3.46%↑*

** “Korea Foundation for Quality“ агентлагийн “Хүлэмжийн хийн ялгаруулалтын баталгаажуулах тайлан”*

Бид компанийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийг Scope 1 болон Scope 2 ангиллын хүрээнд тооцоолон, жил бүр ялгарлын мэдээллийг бүртгэн баталгаажуулалт хийлгэдэг. Тайлант онд Scope 1 болон Scope 2 ангиллын нийт хүлэмжийн хийн ялгаруулалт *28,371 тоннCO_2eq байна.* Цаашид хүлэмжийн хийн ялгарлаа үе шаттайгаар бууруулах боломж, төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

"Скай Хайпермаркет" ХХК нь хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар удирдах, үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, аюулгүй устгах зарчмыг бүх салбар, нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хог хаягдлыг ангилах, зайлуулах, дахин ашиглах, халдваргүйжүүлэх зэрэг үйл явцыг тогтмол зохион байгуулж, салбар бүрийн байршил, онцлогт тохирсон төрийн болон хувийн хэвшлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудтай хамтран ажилладаг.

ЦААШИД ТӨЛӨВЛӨЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Электрон хог хаягдлын менежмент: Бид ирэх онд ашиглалтын хугацаа дууссан электрон хог хаягдлыг хариуцлагатайгаар цуглуулах, ангилан боловсруулах зорилгоор "Нью Тек Мандала" ХХК-тай хамтран ажиллахаар төлөвлөж байна. Тус компани нь электрон хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулах үйл ажиллагааны тодорхой хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулан ажиллуулдаг. Энэхүү хамтын ажиллагаа нь байгаль орчны эрсдэлийг бууруулахаас гадна хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ач холбогдолтой.

Хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулах: Бид салбар дэлгүүрүүдэд лааз болон хуванцар хог хаягдлыг өндөр нарийвчлалтай танин ангилж, цуглуулах боломжтой ухаалаг хогийн савыг байршуулж, ангилан ялгалтыг нэмэгдүүлэх боломжийг судлахаар төлөвлөж байна. Энэхүү шийдэл нь дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг илүү нарийвчлалтай тайлагнах, хог хаягдлын ангилан ялгалтын талаарх мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх давуу талуудтай.

ХОГ ХАЯГДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хог хаягдлын төрөл	Хэмжих нэгж	Хог хаягдлын хэмжээ 2024	Хог хаягдлын хэмжээ 2025	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ
Энгийн хог хаягдал	тн	2,391	4,402	Ангилан ялгаж, гэрээт байгууллагад хүлээлгэн өгч, устгалд шилжүүлэх
Цаас	кг	188,780	389,232	Пресслэн шахаж, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх
Гялгар уут	кг	5446	11,222	Пресслэн шахаж, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх
Тос	л	5,396	22,614	Дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлж, ахуйн хэрэглээний саван болгон ашиглах
Модон подоон	ш	3,345	3,406	Дахин сэргээн ашиглах, боловсруулах үйлдвэрт шилжүүлэх
Аюултай хог хаягдал	кг	57	19.75	Тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар дамжуулан зориулалтын дагуу цуглуулж, устгалд оруулах

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ДАРААЛАЛ

Алхам	Үйл ажиллагааны тайлбар	Хариуцсан тал
1. Анхан шатанд ангилан ялгах	Хогийг төрөл тус бүрээр (цаас, цаасан хайрцаг, хуванцар, шил, энгийн хог хаягдал гэх мэт) ангилах	Үндсэн ажилтнууд
2. Ангилсан хог хаягдлыг пресслэх	Хогоо хаяхдаа ялгасан цаасан хайрцаг, цэвэр цаас, хуванцар хаягдлыг пресслэнэ.	
3. Хэрэглээний хайрцаг цуглуулах	Ялгасан хог хаягдлаас дахин ашиглах боломжтой цаасан хайрцаг цуглуулах. Нөөц хайрцгийг сав баглаа боодлын хэсэгт хүргэх.	Үйлчилгээний ажилтан
4. Хог хаягдал зайлуулах	Хог хаягдлыг 2 цаг тутам зайлуулах, зай талбайг чөлөөлөх.	
5. Ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээ хийх	Хог хаягдлыг цэвэрлэн зай талбайг чөлөөлсний дараа өдөрт 2 удаа тогтмол цагт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.	
6. Хог хаягдлыг тээвэрлэх, хаях	Зай талбайг цэвэрлэж, ариутгал хийсний дараа тээвэрлэлтийн гэрээт компанитай холбогдон, хог хаягдлыг түргэн шуурхай ачуулах.	Хог хаягдал тээвэрлэх гэрээт компани

НОГООН БАЙГУУЛАМЖ БА ОЙЖУУЛАЛТ

“Скай Хайпермаркет” ХХК нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ биологийн олон янз байдлыг хамгаалах, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах зарчмыг тууштай баримталдаг. Бид тусгай хамгаалалттай газар нутаг, ховор амьтан, ургамал бүхий бүс нутагт ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд соёлын өв, байгаль орчныг хүндэтгэх үүргээ бодитой хэрэгжүүлж байна. Тайлант онд өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн байгаль орчны санаачилгуудыг үргэлжлүүлэн ажиллаж байна. Үүнд:

- “Бичил цэцэрлэг” – 1,800 м² (үүнээс 1,300м² нь мод, зүлэг),
- Салбар дэлгүүрийн гадна – 525м² ногоон байгууламж,
- Түгээлтийн төвийн гадна – 660м² ногоон байгууламж.

Эдгээр ногоон байгууламжууд нь байгаль орчны тэнцвэрт байдалд эергээр нөлөөлөхөөс гадна агаарын чанарыг сайжруулж, хотын дулааны хуримтлалыг бууруулахад хувь нэмэр оруулж, ажилтнууд болон үйлчлүүлэгчдийн тав тухтай орчныг бүрдүүлж байна.

“Маргаашийн ой” төсөл: Бид уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтын хүрээнд 2018 оноос эхлэн жил бүр мод тарих төслүүдийг тогтмол хэрэгжүүлж ирсэн. Монгол Улсын цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор Солонгосын Имарт компанийн санаачилга, хөрөнгө оруулалт болон Скай Хайпермаркет ХХК-ийн ажилтнуудын сайн дурын оролцоотойгоор 2024 оноос эхлэн “Маргаашийн ой” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Горхи–Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын 4.4 га талбайд “Хамтын ойн төгөл” -ийг байгуулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны сайн жишгийг бүрдүүлж байна. Төслийн хүрээнд салхины хамгаалалтын зурвас байгуулах, усалгааны болон бусад дэд бүтцийн ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж буй бөгөөд тайлант онд компанийн ажилтнуудын сайн дурын оролцоотойгоор 2 удаагийн тарилт, арчилгааг зохион байгууллаа. Энэхүү төсөл нь голын эргийн ногоон байгууламжийг нөхөн сэргээж цаашид иргэд цэвэр агаарт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхийн зэрэгцээ экологийн мэдлэгээ нэмэгдүүлэх боломжтой ногоон орчин байгуулах ач холбогдолтой юм. 2025 онд компанийн 100 орчим ажилтан оролцон 1,380 ширхэг мод тарьсан бөгөөд модны амьдралт 90%-тай байна.

Хүүхдэд чиглэсэн ногоон санаачилга: Ажилтнуудын гэр бүл, хүүхдүүдийн байгаль орчны боловсролыг дэмжих хүрээнд 2021 оноос эхлэн жил бүр дасан зохицох чадвар сайтай модны үрсэлгээг сонгон бэлэглэж байна. Тайлант онд нийт 1,530 хүүхдэд монос модны суулгацыг, 2024 онд 1,421 ширхэг агч, голт бор модны үрсэлгээг бэлэглэн байгальдаа ээлтэй зөв дадлыг түгээн ажиллав.

ХАМТЫН ОЙН ТӨГӨЛ

Төслийн талбайд таригдсан модны тоо	2025 онд ажилтнуудын тарьсан модны тоо	Модны амьралт
7000+	1380	90%



“ХАМТЫН ОЙН ТӨГӨЛ” 4.4га талбайн ерөнхий зураг



2025 оны мод тарих үйл ажиллагаа



НӨӨЦИЙН ХЭМНЭЛТ БА ЦАХИМЖУУЛАЛТ

“Скай Хайпермаркет” ХХК нь нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжих, цаасны хэрэглээг бууруулах ажлын хүрээнд оффисын болон хэрэглэгчийн үйлчилгээнд цахим шийдлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна. Өмнөх жилүүдэд баримт бичиг болон дотоод хүсэлтүүдийг цахимжуулах, харилцагч байгууллагуудтай мэдээлэл солилцох цахим сувгуудыг ашиглах, автомашины зогсоолын тасалбарыг халж, төлбөрийн киоск ашиглалтад оруулах зэрэг цаасгүй хэрэглээг дэмжих арга хэмжээнүүдийг нэвтрүүлсэн. Тайлант онд эдгээр арга хэмжээг үргэлжлүүлж, цаасны хэрэглээг бууруулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүллээ.

Үйл ажиллагааны автоматжуулалт: Бид urto.mn платформоор харилцагч байгууллагуудтай хамтран ажиллах процессыг цахимжуулж, шинэ бараа нийлүүлэлт, үнийн өөрчлөлт, төлбөрийн нэхэмжлэлийг автоматжуулснаар цаасан баримтын хэрэглээ болон ажлын ачааллыг бууруулсан.

И-баримт хялбар бүртгэл: Ухаалаг хэрэглээг дэмжих зорилгоор “И-баримт хялбар бүртгэл” үйлчилгээг нэвтрүүлэн, худалдан авалтын цаасан төлбөрийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлж эхэллээ.


Цаасан хэрэглээг бууруулах менежмент: Хэвлэлийн хэрэглээг бууруулах зорилгоор PrinterLogic системд хэрэглэгчийн хэвлэх лимитийг өдөрт 20–30 хуудас байхаар тохируулсан бөгөөд ингэснээр санамсаргүй их хэмжээний хэвлэлийг хязгаарлаж байна.

Emart application: Emart app-ийн хөгжүүлэлтийн хүрээнд гишүүнчлэлийн цаасан анкет, хуванцар картны хэрэглээг бууруулж бонус оноо, хөнгөлөлтийн мэдээлэл болон төлбөрийн баримт зэрэг хэрэглэгчийн үйлчилгээнүүдийг үе шаттайгаар цахимжуулж, дижитал бүртгэлийн системд бүрэн шилжээд байна.

QR код бүхий аюулыг мэдээлэх систем: “Аюулыг мэдээлэх хуудас”-ыг QR кодод суурилсан цахим хэлбэрт шилжүүлэн цаасан хэрэглээг бууруулж, мэдээлэх үйл ажиллагааны шуурхай байдал болон ажилтнуудын оролцоог нэмэгдүүлсэн.

Цаашдын зорилт: Тайлант онд байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн дижитал системд шилжүүлэх томоохон төслийн бэлтгэл ажлыг эхлүүллээ. Төслийн хүрээнд байгууллагын олон чиглэлийн үйл ажиллагааг нэгтгэж, санхүү, худалдаа, агуулах, түгээлт, нөөц, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгчийн платформ болон хэрэглэгчийн үйлчилгээ зэрэг одоо ашиглагдаж буй олон системийг цогцоор нь удирдах боломжтой платформыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. ***Энэхүү системийг нэвтрүүлснээр:***

- Системийн хувилбар хоцрогдох, шаардлагатай шинэчлэлээс хоцрох эрсдэлийг бууруулна.
- Давхардсан болон гар ажиллагаатай үйлдлийг автоматжуулж, хөдөлмөр хөнгөвчилнө.
- Тайлан нэгтгэх болон хэвлэх шаардлагыг багасгах
- Барааны нөөцийг илүү бодитоор хянаж, буцаалтын хэмжээг бууруулах боломж бүрдэнэ.
- Бүх төрлийн гэрээг цахимаар боловсруулах, баталгаажуулах боломжтой болсноор цаасны хэрэглээг бууруулах зэрэг олон боломжууд нэмэгдэнэ.





ЦАХИМ ХУДАЛДАА БА НОГООН ТЭЭВЭР

“Скай Хайпермаркет“ ХХК нь 2020 оноос эхлэн emartmall.mn веб сайт болон 2022 оноос Emart Mongolia аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд цахим худалдаа, хүргэлтийн үйлчилгээг тогтмол үзүүлж байна.

Бид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, автомашины яндангаас ялгарч буй хорт утааг багасгах зорилтын хүрээнд 2023 оноос эхлэн цахилгаан мопед болон автомашиныг цахим худалдааны түгээлтийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн өмнөх хугацаанд хүргэлтийн маршрутыг оновчтой болгох зорилгоор What3Words, Google Maps зэрэг системийг нэвтрүүлснээр шатахууны хэрэглээг 11 хувиар бууруулан, ойролцоогоор 38,933 кгCO_2е хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломж бүрдсэн.



ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ХЭМНЭЛТ

2025 онд

22,572 кг CO_2

Хүлэмжийн хийн ялгарал хэмнэгдсэн

22,930

Нийт ногоон хүргэлтийн тоо

82%

Хүргэлтийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт

Шуурхай хүргэлт:
Шуурхай хүргэлт **1~3 цагийн дотор хүргэгдэнэ.** Салбар бүрээс 2км доторх шуурхай хүргэлтээр үйлчлүүлэх боломжтой.


Энгийн хүргэлт :
Улаанбаатар хотын 6-н дүүргийн бүх хороонд хамрагдана.Үйлчлүүлэгчийн захиалга хийх хугацаанаас хамааран хүргүүлэх цагийн сонголт гарч ирнэ.


Зуслангийн хүргэлт :
Улаанбаатар хотын лагерь, зуслангийн 11-н байршлаас захиалга авах ба хүргэлтийн цаг нь 5 ~ **24 цагийн хооронд хүргэгдэнэ.**

Хот хоорондын хүргэлт :
21-н аймаг болон Улаанбаатар хотын алслагдмал 3-н дүүрэгт хүргэлт хийгдэнэ. Хүргэгдэх хугацаа хангаасаа хамааранд **48-72 цаг.**

Өөрөө ирж авах:
Хэрэглэгч захиалга үүсгэж очиж авах салбар болон цаг сонгон захиалгаа өөрөө очиж авах төрөл нэмэгдсэн.

Монгол орны өнцөг булан бүрээс захиалга хийх боломжтой.





4 НИЙГЭМ-ХАРИУЦЛАГАТАЙ ХУДАЛДАА БА ҮЙЛЧИЛГЭЭ

Хүнсний чанар ба аюулгүй байдал
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)
Харилцагчийн үйлчилгээ, санал/гомдлын удирдлага
Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээ

ХҮНСНИЙ ЧАНАР БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хүнсний бүтээгдэхүүний худалдаа, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдал нэн чухал байдаг тул бид үйлчлүүлэгчдээ аюулгүй, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэхийн төлөө онцгой ач холбогдол өгч ажилладаг.

Хүнсний аюулгүй байдал, чанарын удирдлага: Бид Монгол улсын хууль тогтоомж, олон улсын стандартын шаардлагад нийцсэн чанарын удирдлагыг хэрэгжүүлж хүнсний сүлжээний үе шат бүрд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХЭРЭГЖИЛТ:

Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ, хяналт: Манай хүнсний хими, микробиологийн лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 стандартаар 3 удаа итгэмжлэгдсэн бөгөөд мэргэжлийн баг бүрэлдэхүүн дараах хүрээнд шинжилгээ хийж байна:

Микробиологийн чиглэлээр: 11 төрлийн 25 ангиллын бүтээгдэхүүнд 185 үзүүлэлт
Химийн чиглэлээр: 28 төрлийн 9 ангиллын бүтээгдэхүүнд 157 үзүүлэлт

Тайлант онд нийт 7996 нэр төрлийн бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийснээс 3,751 нь шууд импортын, 4,245 нь дотоодын нийлүүлэгчийн бүтээгдэхүүн байна. Мөн лабораторийн талбайн хэмжээг томруулан шинээр багаж анализ хийх өрөөг тохижуулж ажиллах орчин, нөхцөлийг сайжруулсан. Цаашид өндөр мэдрэмжит ICP-OES багаж ашиглан хүнс, хүнс бус бараа бүтээгдэхүүн болон хүрээлэн буй орчны дээжид агуулагдах хүнд металл, макро болон микро элементийн агууламжийг тодорхойлох шинжилгээ хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Бэлтгэн нийлүүлэгч болон үйлдвэрт тавих хяналт: Бид гэрээт харилцагчдаас түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авахдаа чанар аюулгүй байдлыг баталгаажуулсан лабораторийн сорилын дүгнэлт, гарал үүслийн хамт хүлээн авч худалдан борлуулж байна. Түүнчлэн шинэ үйлдвэрлэгчтэй гэрээ байгуулахын өмнө шаардлагатай тохиолдолд үйлдвэрийн аудит (Factory Audit) хийж, ажлын орчин, тоног төхөөрөмж, эрүүл ахуй болон хүнсний аюулгүй байдлын нөхцөлийг үнэлдэг. Үнэлгээний явцад үл нийцэл илэрсэн тохиолдолд, залруулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсний дараа хамтран ажиллах гэрээ байгуулдаг.

2026 онд “Скай Хайпермаркет” ХХК-ийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлын удирдлагын Олон улсын **ISO 22000** стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.





ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ (ХАБЭА)

Бид аюулгүй ажиллагааг ирээдүйд учирч болох эрсдлийг бууруулах суурь чиглэл гэж үздэг бөгөөд зөвхөн дүрэм журам мөрдүүлэхээс гадна, өдөр тутмын хандлага, хариуцлага, хамтын соёл болгохоор зорин ажиллаж байна.

ХАБЭА-н удирдлагын тогтолцоо: Бид ХАБЭА-г Монгол Улсын хууль, тогтоомж, компанийн бодлого, журам болон ISO 45001:2018 стандартад суурилсан тогтолцоогоор удирдан, хэрэгжилтийг нэгжийн удирдлага ханган ажиллаж байна.

ХАБЭА-Н ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХЭРЭГЖИЛТ:

Гүйцэтгэл ба хяналт: ХАБЭА-н эрсдэлийг байгууллагын бүх түвшинд үнэлж, хяналтын арга хэмжээг төлөвлөж, хариу арга хэмжээ авч, үр дүнг тогтмол хянаж байна. Ажлын байр бүрд зааварчилгаа боловсруулж, өдөр тутмын хяналтыг “Аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр”-ээр дамжуулан хэрэгжүүлж байна.Тайлант онд бүх салбар дэлгүүр болон төв агуулахад ХАБЭА-н иж бүрэн хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчлийг 85 хувиар бууруулж, ажлын байрны сайжруулалтын арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан. 2025 онд эндэгдэлгүй ажиллаж, нэг үйлдвэрлэлийн осол бүртгэгдэн, 734 хүнийг галын аюулгүй байдлын сургалтад амжилттай хамруулаа. Мөн тэрэг, зогсоолын ажилтнуудын ажлын хантаазыг сэрүүцүүлэгч сэнстэй болгож, ажлын байрны эрсдэлийг бууруулсан. Сэнстэй хантаазны аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгааг боловсруулж, мэдээлэл, танилцуулга хийсэн.

Сургалт, чадавхжуулалт: Ажилтнуудыг ХАБЭА болон анхан шатны тусламжийн сургалтад хамруулж, хууль, дүрмийн дагуу төлөвлөгөөт сургалтуудыг улирал тутам зохион байгуулан нийт ажилтны хамрагдалт 86 хувьд хүрсэн.
Ажлын байр болон амралтын өрөөнд 12 төрлийн ХАБЭА-н видео хичээл байршуулж, ажилтнуудын өөрөө суралцах боломжоор хангаж байна

Гал түймэр, онцгой байдлын аюулгүй ажиллагаа: Онцгой байдлын Ерөнхий газартай хамтран улсын гэрээт хяналтын ахлах байцаагч байнгын ажиллан гамшиг, галын эрсдэлийг тогтмол хянан, мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд галын аюулгүй байдлын үзлэгийг бүх салбарт тогтмол хийж, галын аюулгүй байдлын сургалтад 516 ажилтан, 218 түрээслэгчийг хамруулсан.

Нийлүүлэгч, гүйцэтгэгчийн аюулгүй ажиллагаа: Нийлүүлэгч, гүйцэтгэгч байгууллагуудын ХАБЭА-н шаардлагад гэрээний шатнаас эхлэн анхаарч ажил эхлэхийн өмнөх зааварчилгаа, ажлын явцын хяналт болон өндөр эрсдэлтэй ажилд тусгай хяналтын тогтолцоог мөрдүүлж ажиллаж байна.

Цаашдын зорилт: Бид цаашид сургалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, ажлын байрны аюулыг мэдээлэх соёлыг төлөвшүүлэх, галын аюул, нүүлгэн шилжүүлэлт, анхан тусламжийн дадлага сургуулилтын давтамжийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.




ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, САНАЛ ГОМДЛЫН УДИРДЛАГА


Бид харилцагчийн үйлчилгээ, санал гомдлын удирдлага нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чухал хэсэг гэж үздэг. Иймд “Хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааны журам”–ын хүрээнд, гомдлыг түргэн шуурхай хүлээн авч шийдвэрлэхэд анхааран ажиллаж байна.

Чанар, аюулгүй байдалтай холбоотой санал: Бид энэ төрлийн гомдлыг эрсдэлийн түвшнээр ангилан “Low” болон “Medium” түвшний гомдлыг 3 хоногийн дотор, “High Risk” түвшний гомдлыг 5 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлт, лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн хугацааг сунгаж, хэрэглэгчдэд шийдвэрлэлтийн явцын талаар тогтмол мэдээлэл хүргэдэг.

САНАЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ



САНАЛ ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ СУВАГ



Сэтгэл ханамжийн судалгаа: Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор салбар дэлгүүрүүдийн хэмжээнд улирал тутам судалгаа зохион байгуулж, үйлчилгээний чанарыг “Элдэг Имарт”, “Цэвэрч Имарт”, “Аюулгүй Имарт”, “Тав тухтай Имарт”, “Шуурхай Имарт” гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр үнэлдэг. Судалгааны үр дүнд үндэслэн хэрэглэгчдийн санал хүсэлт, шинэ санаачилгыг үйл ажиллагаанд тусгаж, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

“Self Checkout” үйлчилгээ: Бид үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, дэлгүүрийн урсгалыг оновчтой зохицуулах, зорилгоор өөртөө үйлчлэх “SELF CHECKOUT” боломжийг нэмлээ. Худалдан авагчдын дунд энэхүү үйлчилгээний хэрэглээ тогтмол өсөж, нийт худалдан авалтын дунджаар 3.8 хувийг эзэлсэн бөгөөд 12 дугаар сард 5.42 хувьд хүрсэн байна. Энэхүү шийдэл нь хэрэглэгчдэд төлбөр тооцоогоо бие даан, түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ кассын ачааллыг бууруулж хэрэглэгчдийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлж байна.





ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ

“Скай Хайпермаркет” ХХК нь ханган нийлүүлэгчид болон бизнесийн түншүүдтэйгээ урт хугацааны, хариуцлагатай хамтын ажиллагааг эрхэмлэн ажилладаг. Бид ханган нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, бизнесийн ёс зүй, хууль эрх зүйн нийцлийг хангахад, анхааран ажиллаж байна.

Дотоодын үйлдвэрлэгчдийн дэмжлэг: Дотоодын үйлдвэрлэгчид, тариаланчид, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих нь компанийн тогтвортой байдлын тэргүүлэх чиглэлүүдийн нэг юм. Энэ хүрээнд “Хөх шошго” хөтөлбөрөөр дамжуулан дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд илүү хялбараар ялган таних, сонголт хийх боломжийг бүрдүүлж байна. Мөн “Women-Owned” санаачилгад нэгдэн эмэгтэй бизнес эрхлэгчдийн хөгжил, зах зээлийн оролцоог дэмжин ажиллаж байна. Үүний зэрэгцээ хүнсний ногоо, сүү, мах зэрэг бүтээгдэхүүнийг тариаланч, фермерүүдээс шууд худалдан авах замаар нийлүүлэлтийн үе шатыг богиносгож, үр ашгийг нэмэгдүүлэн, хэрэглэгчдэд шинэхэн, чанартай бүтээгдэхүүнийг тасралтгүй хүргэж өдөр тутмын хэрэгцээт бүтээгдэхүүнд хүртээмжтэй үнийн бодлого баримтлан ажиллаж байна.

Нийүүлэлтийн стандарт: Бид шинэ харилцагч, түрээслэгчийг сонгохдоо тухайн байгууллагын өрсөлдөх чадвар, бараа бүтээгдэхүүний ялгарал, хууль эрх зүйн байдал, санхүүгийн тогтвортой байдал зэргийг хамарсан үнэлгээний шалгуур ашигладаг бөгөөд сонгон шалгаруулалт 80 хувиас дээш үнэлгээг хангасан тохиолдолд хийгддэг. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн хувьд үйлдвэрлэлийн орчинд үнэлгээ хийж, үйлдвэрлэлийн нөхцөл, хадгалалт, эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилтийг үнэлдэг.

Үйлдвэрлэл ба инноваци: Бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийг нэгтгэсэн Хүнс хөгжүүлэлт, судалгааны төвийг 2023 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан. Тус төв нь бүтээгдэхүүний амт, чанарын стандартыг хангах зорилготой бөгөөд Имартын бүх салбарыг 30 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр найдвартай ханган ажиллаж байна. Түүнчлэн хэрэглэгчдийг жилийн турш шинэхэн навчит хүнсний ногоогоор хангах зорилгоор гидропоник хүлэмжийн технологийг нэвтрүүлэн ажиллаж байна. Гидропоник технологи нь уламжлалт тариалалттай харьцуулахад усны болон пестицидийн хэрэглээг бууруулахын зэрэгцээ базил, минт, микро грийн зэрэг хязгаарлагдмал нийлүүлэлттэй ногооны хангамжийг нэмэгдүүлж, импортын хамаарлыг бууруулахад хувь нэмэр оруулж байна. Цаашид автоматжуулалт, үйлдвэрлэлийн хүчин чадлаа үе шаттайгаар нэмэгдүүлэх, хүнсний болон, мах боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Хариуцлагатай ханган нийлүүлэлтийн сүлжээ: Компани нь ханган нийлүүлэгчдээс бизнесийн ёс зүй, хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний эрх, байгаль орчны хариуцлагыг баримтлахыг шаарддаг. Үүнийг хангах зорилгоор “БИЗНЕСИЙН ТҮНШИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ”-ыг мөрдөхийг зөвлөмж болгон, хариуцлагатай бизнесийн орчныг хамтдаа бүтээхээр ажиллаж байна. Мөн ханган нийлүүлэгчтэй байгуулах гэрээнд Байгаль орчин, нийгэм хамгааллын заалтыг тусгаж ажилладаг.

БИЗНЕСИЙН ТҮНШИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

1. Үнэн зөв мэдээлэл
Ил тод, үнэн зөв, бодит мэдээлэл солилцох

2. Хуулийн нийцэл
Холбогдох хууль, стандарт, журмыг мөрдөх.

3. Ил тод, шударга харилцаа
Ижил тэгш, ялгаварлан гадуурхалтаас ангид бизнесийн харилцааг эрхэмлэх.

4. Авлига ашиг сонирхлын зөрчил
Авлига, хээл хахууль болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

5. Мэдээллийн нууцлал
Нууц мэдээллийг хамгаалж, зохистой ашиглах.

6. Ёс зүйн зөрчлийг мэдээлэх
Ес зүйн зарчмыг зөрчсөн нөхцөл байдалд орсог бол мэдээлэх.

7. Хүний эрх, хөдөлмөрийн шударга нөхцөл
Хүний эрх, хөдөлмөрийн шударга нөхцөлийг хүндэтгэх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихгүй байх.

8. Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа Нөөцийн хэмнэлттэй, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах.

9. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал
Эрүүл аюулгүй ажлын орчныг бүрдүүлж, урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах.

10. Хууль бус үйл ажиллагааг хориглох
Аливаа хууль бус болон ёс зүйгүй үйл ажиллагаанаас ангид байх.

11. Тогтвортой хөгжлийг дэмжих
Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын зарчим болон Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжих.

12. Оюуны өмч
Оюуны өмчийн эрхийг зөрчихгүй, хамгаалж ажиллах.

ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ БҮТЭЦ

756
Дотоодын нийлүүлэгч


173
Түрээслэгч байгууллага

929
Дотоодын нийт харилцагч

223
Импортын нийлүүлэгч

1152
Нийт харилцагч байгууллага

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ОРОЛЦОО



Мэдээллийг бөглөсөн 486 байгууллагын 56.2% нь эмэгтэй эзэмшигч, удирдлагатай байна.

Эмэгтэй эзэмшигч, удирдлагатай байгууллагын ангилал

20 болон түүнээс дээш хувь нь эмэгтэй эзэмшигчтэй ба эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай (CEO/COO/Ерөнхийлөгч/Дэд ерөнхийлөгч) харилцагч — **29%**

20 болон түүнээс дээш хувь нь эмэгтэй эзэмшигчтэй ба ТУЗ-н 30-аас доошгүй хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлдэг харилцагч — **3%**

Компанийн 51% ба түүнээс дээш хувь нь эмэгтэй эзэмшигчтэй харилцагч — **68%**

ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ



Made4U

Дотоодын үйлдвэрлэгчидтэй хамтран Made4U брэндийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж байна.

4
Дотоодын үйлдвэрлэгч

10
Нийт бүтээгдэхүүн





Тайлант онд харилцагч байгууллагын **80.6** хувь нь дотоодын харилцагч байгууллага байсан бөгөөд нийт борлуулалтын **77.2** хувийг дотоодын худалдан авалт бүрдүүлж байна.

2024 оноос дотоодын харилцагч байгууллагуудаас Urtoo.mn цахим системээр дамжуулан жендэрийн судалгаа авч эхэлсэн. Өнөөдрийн байдлаар нийт дотоодын харилцагч байгууллагуудын **52.3** хувь нь судалгаанд хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан байгууллагуудын **56.2** хувь нь эмэгтэй эзэмшигч болон удирдлагатай байна. Цаашид судалгааны хамрагдалтыг нэмэгдүүлж, нийт харилцагч байгууллагуудыг хамруулахын зэрэгцээ судалгааны үр дүнд үндэслэн эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллана.

ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ


Бид хэрэглэгчдэд чанартай, аюулгүй, үнэ цэнийн хувьд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн хүргэх зорилтын хүрээнд өөрийн нэрийн (PL) бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг өргөжүүлж байна. 2025 онд хэд хэдэн шинэ PL бүтээгдэхүүнийг амжилттай хөгжүүлэн худалдаанд гаргаж, хэрэглэгчдэд чанарын өндөр стандарт хангасан бүтээгдэхүүнийг илүү хүртээмжтэй үнээр санал болгож байна. Энэхүү санаачилга нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хариуцлагатай, тогтвортой хэрэглээг дэмжихэд чиглэж байна.

Made4U

ТАНД ЗОРИУЛСАН АМТ



Дотоодын **4** үйлдвэрлэгчидтэй хамтран өөрийн **"Made4U"** брэндийн **10** гаруй бүтээгдэхүүнийг хөгжүүлэн, үндэсний үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж байна.



5 НИЙГЭМ-ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Хүний нөөцийн бодлого
Олон талт, хүртээмжтэй ажлын байр
Ажиллах орчин, ажилтны сайн сайхан байдал
Сургалт ба ажилтны хөгжлийн хөтөлбөр

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

“Скай Хайпермаркет” ХХК нь үйлчилгээний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг ажилтнуудын ур чадвар, ажлын орчинтой салшгүй холбоотой гэж үздэг. Иймд бид хүний нөөцийг үндсэн чиглэл болгон ажилтны сэтгэл ханамж, ажил амьдралын тэнцвэр, сурч хөгжих боломжийг дэмжсэн шийдлүүдийг хэрэгжүүлж байна.

АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

Ажилтны сэтгэл ханамж 2024 оноос 8% өсөлттэй байна.



Бид ажилтны дуу хоолойг сонсох, сэтгэл ханамжийг үнэлэх, үр дүнд үндэслэн ажлын орчныг тасралтгүй сайжруулах зорилгоор ажилтны сэтгэл ханамжийн судалгааг нийт ажилтны дунд жил бүр тогтмол зохион байгуулж байна. Тайлант онд ажилтны сэтгэл ханамж өмнөх оноос 8 хувийн өсөлттэй байна. Цалин хөлс, карьер болон сургалт хөгжил, удирдлагын манлайлал зэрэг үзүүлэлт сайжирсан нь үнэлгээнд голлон нөлөөлөв.

АЖИЛТНЫ ХАЛАМЖ БА ДЭМЖЛЭГ:

Ажилтанд уй гашуу тохиолдсон үед үзүүлэх дэмжлэг: Ажилтанд гэр бүлийн болон хувийн уй гашуу, хүнд нөхцөл байдал тохиолдсон үед сэтгэлзүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлж 2025 онд 50 ажилтанд 67,794,000 төгрөгийн дэмжлэг олголоо.

Байгалийн гамшигт өртсөн ажилтанд үзүүлэх дэмжлэг, тусламж: Ажилтан болон түүний гэр бүл байгалийн гамшиг, гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас орон гэр, эд хөрөнгөөр хохирсон тохиолдолд шуурхай дэмжлэг, тусламж үзүүлэх тэтгэмжийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Гэр бүлд ээлтэй бодлого: Компанийн зүгээс ажилтнуудын амьдралын чухал үе шатуудад дэмжих зорилгоор ажилтан гэрлэх, хүүхэдтэй болох үед дэмжлэг, урамшууллын бодлогыг хэрэгжүүлдэг. 2025 онд нийт 41 ажилтан шинэ хүүхэдтэй болж, бүл нэмжээ.

Эрсдэлийн хуримтлал: Ажилтны санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор “Эрсдэл хуримтлалын сан”-г хэрэгжүүлж, ажилтан 3 хувь, ажил олгогч 5 хувийн хуримтлалыг ажилтны нэрийн дансанд сар бүр төвлөрүүлдэг. Хуримтлалд хүү тооцож, онцгой нөхцөлд буцаан авах боломжийг бүрдүүлсэн.

Сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө:Бид “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-тэй хамтран гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх сургалт, зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэдэг. Цаашид ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих хүрээнд мэргэжлийн сэтгэл зүйчтэй урт хугацаанд хамтран ажиллаж оношилгоо, зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэх, хиймэл оюунд суурилсан дижитал шийдлийг давхар нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

АЖИЛТНЫ ОРОЛЦОО, УРАМШУУЛАЛ

Ажилтны хөнгөлөлттэй худалдан авалт: Ажилтнууд байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон хамтрагч байгууллагын хөнгөлөлтөд хүртээмжтэй нөхцөлөөр хамрагдах боломжоор нийт 1107 ажилтан хамрагдлаа.

Шагнал, урамшуулал: Компанийн зүгээс ажилтны хөдөлмөр, амжилт, байгууллагад оруулсан хувь нэмрийг үнэлэн тайлант хугацаанд 142 ажилтныг 320,000,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Дотоод харилцаа, мэдээллийн хүртээмж: Ажилтны оролцоо, мэдээллийн хүртээмжийг сайжруулах хүрээнд сар бүр цахим сонин хэлбэрээр онцлох үйл ажиллагаа, ажилтны амжилт, дэвшил, шинэ ажилтны мэдээлэл, дотоод шилжилт хөдөлгөөн, байгууллагын соёлтой холбоотой мэдээллийг тогтмол түгээж байна.

Ажилтны эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих: Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 онд 575 ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Мөн эрүүл мэндийн сайн дурын даатгалын хөтөлбөрийг 6 дах жилдээ амжилттайгаар хэрэгжүүллээ.

ОЛОН ТАЛТ, ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

Компанийн хүний нөөцийн бодлого нь хүйс, нас, үндэс угсаа, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлог, гэр бүлийн байдал, итгэл үнэмшил, нийгмийн байдал зэргээс үл хамааран ажилтнуудад тэгш эрхтэй, аюулгүй, хүндэлтэй хөдөлмөрийн орчин бүрдүүлэхэд чиглэж байна.

Жендерийн тэгш оролцоо: Компанийн 1503 ажилтны 64,3%-ийг эмэгтэй ажилтнууд эзэлж, 102 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй, ажлын байр хадгалагдсан байна. Мөн удирдах албан албан тушаалын 60%-д эмэгтэй ажилтнууд ажиллаж байна.


Тэгш оролцоо, хүртээмж: Хүртээмжтэй, олон талт ажлын орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд тайлант онд 41 хөгжлийн бэрхшээлтэй ажилтан болон 101 ахмад насны ажилтанд тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

НИЙТ АЖИЛТАНЫ ТОО *(НАСНЫ БҮТЦЭЭР)*


НИЙТ АЖИЛТАН
1,503
2025 оны байдлаар

Өнгөрсөн оноос
+259
ажилтан

↑20.8%
2024: 1,244




ЖЕНДЭРИЙН ТЭГШ ОРОЛЦОО



Эмэгтэй
966
ажилтан

Эрэгтэй
537
ажилтан

Удирдах ажилтан



30 ажилтан | **20 ажилтан**

Жирэмсэн болон хүүхэд асрах чөлөөтэй
102
ажилтан

ОЛОН ТАЛТ БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖ

Хөгжлийн бэрхшээлтэй
41
ажилтан

Эмэгтэй	Эрэгтэй
19 ажилтан	22 ажилтан
46%	54%

Ахмад насны
101
ажилтан

Цагийн ажилтан
917
ажилтан

Эмэгтэй	Эрэгтэй
571 ажилтан	346 ажилтан
62%	38%

АЖИЛЛАХ ОРЧИН, АЖИЛТНЫ САЙН САЙХАН БАЙДАЛ

АЖЛЫН ОРЧИН
Бүтээмжтэй хамтын ажиллагааг дэмжих ажлын орчин.

ТӨВ ОФФИС
2025 онд нийт 4,760 м² талбай бүхий үндсэн оффисын хэсэг болон 1,000 м² тохижилттой ашиглалттай дээврийн талбайтай орчин үеийн оффисын цогцолборыг ашиглалтад оруулаа.

АЖИЛТНЫ ТАВ ТУХ
Чөлөөт цаг, эрүүл мэнд, тав тухыг дэмжих амрах хэсэг.

АЖЛЫН ОРЧИН БА ТАВ ТУХ
Ажилтнуудын чөлөөт цаг, эрүүл мэнд, тав тухыг дэмжих зорилгоор амралтын хэсэг, спорт болон иогийн өрөө, хүүхдийн өрөө, номын сан бүхий орчныг бүрдүүлж, мөн зочдод зориулсан тав тухтай хүлээлгийн хэсгийг оффисын шийдэлд тусгасан.

ХҮЛЭЭН АВАХ ОРЧИН
Харилцагч байгууллага, зочдод зориулсан хүлээлгийн хэсэг

ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ АЖЛЫН ОРЧИН
Компанийн зүгээс хүүхдийн өдөр өнжүүлэх, ажилтны зуслан, амралт сувиллын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Ирэх онд төв оффисын ажилтнуудад 08:00–10:00 цагийн хооронд ажлаа эхлүүлэх боломжтой уян цагийн системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.













СУРГАЛТ БА АЖИЛТНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТ ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

Багц-1 Дасан зохицуулах хөтөлбөр	***Багц-2*** Ур чадварын моделийн дагуух хөтөлбөр	***Багц-3*** Карьер хөгжүүлэх хөтөлбөр	***Багц-4*** Захиалгат сургалтын хөтөлбөр	***Багц-5*** Байгууллага хөгжүүлэлтийн хөтөлбөр
Имартын хүсэмжит ажилтны ойлголтыг өгөх, Компанидаа богино хугацаанд дасгах	Албан тушаалын түвшин бүрд шаардах ур чадварыг олгох	Ажилтан түвшин ахиж албан тушаал дэвшихэд бэлтгэх	Нарийн мэргэжлийн болон дотоод нөөцөөр өгөх боломжгүй дутагдаж буй ур чадваруудыг олгох	Байгууллагын эерэг соёлыг бэхжүүлэх, ажилтны гэр бүл, эрүүл мэнд, санхүүгийн боловсролд мэдлэг нэмэх

Сургалт ба хөгжлийн бодлого: “Скай Хайпермаркет” ХХК нь ажилтны ур чадвар, мэргэжлийн өсөлт, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор шаталсан сургалт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байна. Компанийн сургалт, хөгжлийн бодлого нь ажилтны зөвхөн тухайн албан тушаалд тохирох чадвартай байлгахаас гадна ирээдүйн удирдагч, мэргэшсэн мэргэжилтэн болгон хөгжүүлэх зорилготой. Ур чадварт суурилсан ажлын байран дээрх сургалтуудыг дотоод сургагч багш нар хариуцаж бусад мэргэжлийн мэргэшүүлэх сургалтуудыг гаднын сургагч багш нартай хамтран хүний нөөцийн менежерүүд зохион байгуулдаг. 2025 онд давтагдсан тоогоор 3004 ажилтан сургалтад хамрагдсан бөгөөд ажилтны дундаж сургалтын цаг 10.9 цаг байсан.

2025			
Ажилтны сургалтын бүртгэл /нийт цаг/	**9,438**	Ажилтны жилийн дундаж сургалтын цаг	**10,9**
Эрэгтэй	2,831	Эрэгтэй	6,54
Эмэгтэй	6,607	Эмэгтэй	15,26
Нийт сургалтад хамрагдсан ажилтны тоо /давхардсан тоогоор/			3004

Боловсролын дэмжлэг: Ажилтнуудын мэдлэг, ур чадвар, мэргэжлийн хөгжлийг дэмжих хүрээнд боловсролын тэтгэмж, сургалтын дэмжлэгийн бодлогыг хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд нийт 7 ажилтныг дээд болон ахисан түвшний боловсрол эзэмшүүлэхээр их, дээд сургуульд элсүүлсэн.

93 ажилтан
Гадны сургалтад хамрагдсан

7 ажилтан
Боловсролын дэмжлэгээр их, дээд сургуульд элссэн





6 ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл
Гүйцэтгэх удирдлагын бүтэц
Хариуцлагатай манлайлал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ

ТУЗ-н дарга	ТУЗ-н гишүүн	ТУЗ-н гишүүн	ИМАРТ ИНК-н гишүүн
			
Б.БАТТҮШИГ	Б.САМАДИ	Б.БАДАМХАНД	КАН ЁН СОК

“Скай Хайпермаркет” ХХК компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 4 гишүүнтэй бөгөөд, 1 хараат бус гишүүн, 1 эмэгтэй гишүүнээс бүрддэг. 2024 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлд анх удаа эмэгтэй гишүүн томилогдож, жендерийн бүтэц илүү тэнцвэртэй болсон. Төлөөлөн удирдах зөвлөлийн үндсэн чиг үүрэг нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон компанийн дүрэмд заасны дагуу компанийн урт хугацааны стратегийн чиглэл, бодлогыг тодорхойлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл нийт 4 удаа хуралдаж, компанийн стратегийн болон томоохон үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БҮТЭЦ




Л.ЖАВЗМАА
Гүйцэтгэх захирал



ЮН ЁН ГИЛЬ
Хамтын ажиллагааны захирал



СУ ЖИНЬ СОНЬ
Стратеги төлөвлөлт NO Brand эрхэлсэн дэд захирал



Б.САМАДИ
Худалдаа эрхэлсэн дэд захирал



Б.БОЛОРМАА
Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал



М.ДОРЖЛХАГВА
Хөрөнгө хөгжүүлэлт эрхэлсэн дэд захирал



Э.ХАЛИУН
Захиргаа, хүний нөөц эрхэлсэн дэд захирал



З.БААСАНЖАРГАЛ
Борлуулалт, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал



Т.АЛТАНХУНДАГА
Маркетинг, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал

ХАРИУЦЛАГАТАЙ МАНЛАЙЛАЛ

“Скай Хайпермаркет” ХХК нь ил тод байдал, ёс зүй, хариуцлагатай манлайлалд суурилсан засаглалын зарчмыг баримтлан ажилладаг. Бид компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчид, хэрэглэгчид, ажилтнууд болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хангах, компанийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах үндэс гэж үздэг.

Эрсдэлийн удирдлага ба хяналтын тогтолцоо: Эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл ажиллагааг Дотоод аудитын хэлтэс хэрэгжүүлэн, компанийн хэмжээнд дотоод болон гадаад эрсдэлийг тогтмол үнэлж, хяналт тавин ажилладаг. Тайлант хугацаанд технологийн шинэчлэл, хяналтын системийн сайжруулалтаар гадаад эрсдэлийг бууруулахад бодит ахиц гаргасан. Цаашид аудитын хамрах хүрээг өргөжүүлэх, аудитын чиг үүргийг үе шаттайгаар нэгтгэхээр ажиллаж байна.

Хууль тогтоомжийн нийцэл: Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, компанийн дотоод бодлого, журам болон франчайзын гэрээний шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлдэг. Хууль эрх зүйн өөрчлөлтийг тогтмол хянан, шаардлагатай шинэчлэлийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажилладаг. Компани нь гэрээ, хамтын ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, хүний эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, бизнесийн ёс зүйн шаардлагыг тусгасан Байгаль орчин, нийгмийн хамгааллын заалтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Мэдээллийн аюулгүй байдал: Компанийн мэдээллийн аюулгүй байдлыг бэхжүүлэх хүрээнд олон нийтэд нээлттэй системүүдэд аюулгүй байдлын үнэлгээ хийж, илэрсэн эрсдэлүүдийг бууруулах болон сайжруулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн нийт ажилтан мэдээллийн аулгүй байдлын мэдлэг олгох анханшатны сургалтыг тогтмол орж, системүүдэд илэрсэн зөрчлүүдэд шуурхай хариу арга хэмжээ авч зөвлөмж өгч байна. Түүнчлэн зөвлөх байгууллагатай хамтран ISO/IEC 27001:2023 стандартын дагуу үнэлгээ хийж, цаашид сайжруулах чиглэлээ тодорхойлсон. Цаашид мэргэжлийн байгууллагатай хамтран мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, системүүдийн эмзэг байдлын үнэлгээг тогтмол хийж аюулгүй байдлын тогтолцоогоо сайжруулахаар төлөвлөж байна.

Ил тод байдал ба хариуцлагын тогтолцоо: Компанийн ил тод, хариуцлагатай засаглалыг хангах хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улирал бүр тогтмол зохион байгуулж хувьцаа эзэмшигчидэд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол хүргэж ажилладаг. Хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын “Имарт Инк” компани нь Төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөлөлтэй бөгөөд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол авч, бизнес төлөвлөгөө батлах, дэд захирлуудыг томилох, томоохон хөрөнгө оруулалт болон санхүүжилт зэрэг чухал шийдвэрүүдийг хамтран хэлэлцэж ажилладаг.

Ёс зүй ба шударга байдал: “Скай Хайпермаркет” ХХК нь ёс зүй, шударга, ил тод байдалд тулгуурлан үйл ажиллагаагаа эрхэлдэг бөгөөд компанийн хариуцлагатай бизнесийн соёлыг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд 2025 онд компанийн нийт ажилтанд мөрдүүлэх “Ёс зүйн 12 зарчим”, мөн хамтран ажиллагч харилцагч, нийлүүлэгч, бизнесийн түншүүдэд баримтлах “Бизнесийн түншийн ёс зүйн зарчим”-ыг батлан хэрэгжүүлж эхэллээ. Ажилтнууд “Ёс зүйн 12 зарчим”-ыг тогтмол зохион байгуулагддаг дотоод сургалтаар дамжуулан танилцаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Хамтран ажиллагч харилцагч, нийлүүлэгч, бизнесийн түншүүд “Бизнесийн түншийн ёс зүйн зарчим”-тай танилцан хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд, шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

ЗАСАГЛАЛЫН ТУЛГУУР ЧИГЛЭЛ

1. Ил тод байдал ба хариуцлага
2. Ёс зүй ба шударга байдал
3. Хууль тогтоомжийн нийцэл
4. Эрсдэлийн удирдлага ба хяналтын тогтолцоо
5. Мэдээллийн аюулгүй байдал

АЖИЛТНЫ “ЁС ЗҮЙН 12 ЗАРЧИМ”

1. Хууль, дотоод дүрэм журмыг мөрдөх
2. Шударга байдлыг эрхэмлэх
3. Харилцааны соёлыг сахих
4. Авлига, хээл хахуулыг хатуу хориглох
5. Хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
6. Хүний эрх, хөдөлмөрийн стандартыг хангах
7. Ил тод ажиллагааг баримтлах
8. Байгаль орчинд ээлтэй байх
9. Мэдээллийн нууцлалыг чандлах
10. Мэргэжлийн хандлагатай байх
11. Баримтжуулалт, архивыг бүрдүүлэх
12. Ёс зүйн зөрчлийг мэдээлэх



7 ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА (CSR)

Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа (CSR)

ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА (CSR)

“Скай Хайпермаркет” ХХК нь бизнесийн өсөлт, тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан нийгмийн хариуцлагыг үндсэн үнэт зүйл болгон хэрэгжүүлдэг. Бид ажилтнуудын сайн сайхан байдлыг дэмжихийн зэрэгцээ нийгмийн бүх түвшинд – олон нийт, хүүхэд, залуусын боловсрол, тэгш оролцоо, байгальд ээлтэй дадал, хамтын оролцоо зэрэг салбарт бодит хувь нэмэр оруулсаар байна.



5 ӨНГИЙН АЯН - 2025

Хүүхдүүдэд эрүүл, зөв хооллолтын боловсрол олгох, , жимсний өнгө бүр өөр өөрийн, шим тэжээл, эрүүл мэндэд үзүүлэх ач тустай болохыг амталж ач холбогдлыг таниулах зорилготой 5 өнгийн сургалтыг 2017 оноос хойш тогтмол зохион байгуулж байна. Сургалтаар хүүхдүүд “Имарт”-ын Гүемтэй танилцаж, худалдан авалтын эрхийн бичгээр жимс худалдан авах замаар бие даан худалдан авалт хийх дадалд суралцсан.



ХҮРТЭЭМЖТЭЙ ЦЭЦЭРЛЭГ

НҮБ-ын Хүүхдийн Сан, БНСУ-ын Имарт, ChildFund Korea болон Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын хамтын санхүүжилтээр Баянзүрх дүүргийн 64 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн 1,800 м² талбай бүхий барилгыг ашиглалтад оруулаа. Энэхүү хөрөнгө оруулалт нь зорилтот бүлгийн 115 гаруй хүүхдүүдийн суралцах, хөгжих эрхийг бодитоор хангах зорилготой бөгөөд гэрэл гэгээтэй уужим анги танхим, нарны эрчим хүч зэрэг шийдлүүдтэй.



ИТГЭЛ ДҮҮРЭН ЦҮНХ

“Veloo Foundation”-тай хамтран зорилтот бүлгийн бяцхан сурагчдад чиглэсэн сайн үйлсийн аяныг хэрэгжүүллээ. Аяны хүрээнд Улаанчулуут орчмын “Нарны хүүхдүүд” цэцэрлэгийн сурагчдад 60 ширхэг хичээлийн цүнх, хэрэгсэл хандивлаж, хүүхдийн хөгжил, бүтээлч сэтгэлгээг дэмжих зорилгоор “Имартын нэг өдөр” тоглоом бэлэглэлээ.



ИТГЭЛ ДҮҮРЭН ЦҮНХ

“Скай Хайпермаркет” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-ийн түр хамгаалах байранд байрлаж буй хүүхдүүдэд зориулан итгэл найдвар, урам зориг өгөх “Итгэл дүүрэн цүнх”-ийг 4-16 насны 20 хүүхдэд хандивлалаа.

ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА (CSR)



ИТГЭЛ НАЙДВАРАА ХУВААЛЦЪЯ

Бид жил бүр цагаан сарын баяраар салбар дэлгүүрийнхээ ойр, орчимд оршин суудаг, тусламж дэмжлэг шаардлагатай өндөр настнуудыг дэмжих зорилгоор ажилтнууд өөрсдийн гараар, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд, зориулалтын хөргүүрт хөлдөөж бэлтгэсэн буузыг бэлэглэдэг уламжлалтай. Тайлант онд нийт 16545 ширхэг бууз хийж 67 ахмад наснууддаа тараасан байна.



ХАМГААЛАЛТЫН ДУУЛГА

Сонгинохайрхан дүүргийн Тээврийн Цагдаагийн хэлтэстэй хамтран хөл хөдөлгөөн ихтэй бүсэд скүүтэр, цахилгаан болон унадаг дугуйтай холбоотой замын хөдөлгөөнд оролцож байгаа хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор 1,000 ширхэг хамгаалалтын дуулга бэлэглэлээ. Хамгаалалтын дуулга нь ослын үед толгойг хамгаалж, хүнд гэмтэл авах эрсдэлийг бууруулах чухал ач холбогдолтой.



ХҮҮХДИЙН ЦАЦРУУЛАГЧ

Замын хөдөлгөөн ба хүүхэд аяны хүрээнд 1–3 дугаар ангийн 5,000 хүүхдэд цацруулагч зүүлт тараалаа. Цацруулагч зүүлт нь шөнө, орой үзэгдэх орчин хязгаарлагдмал үед хүүхдийн харагдах байдлыг сайжруулж, жолооч нарт 250–300 метрийн зайнаас танигдах боломжийг бүрдүүлснээр замын хөдөлгөөнд илүү аюулгүй оролцоход дэмжлэг үзүүлдэг.



POLICE SUPPORT ZONE

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, “Покет ББСБ” ХХК, болон “Скай Хайпермаркет” ХХК хамтран олон нийтэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл түгээх, зөвлөгөө өгөх зорилготой “Police Support Zone”-г байгуулж, 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр үйл ажиллагааг эхлүүллээ. Энэхүү буланг байгуулснаар хэрэглэгчид Имарт дэлгүүрээр үйлчлүүлэх явцдаа хууль эрх зүйн зөвлөгөө авах, цахим гэмт хэргээс хамгаалах мэдлэгээ нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА (CSR)

MYOX-НЫ “АЛТАН ТҮНШ” БАЙГУУЛЛАГА

“Скай Хайпермаркет” ХХК нь нийтийн биеийн тамир, спортыг дэмжих чиглэлээр тогтмол ажиллаж 2018 болон 2023 онуудад Монголын Үндэсний Олимпын Хорооны “Мөнгөн түнш” байгууллагаар хамтран ажиллаж ирсэн. Тайлант онд энэхүү үйл ажиллагааг өргөжүүлэн MYOX-той “Албан Ёсны - Алтан Түнш” байгууллагаар хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Имарт нь Албан ёсны Алтан түнш болсноор MYOX-оос олимп, тив, дэлхийн наадамд оролцох баг тамирчдын бэлтгэл сургуулилт, тэмцээн уралдаанд онцгой эрхтэйгээр дэмжлэг үзүүлэн ажиллах юм. Санамж бичгийн хүрээнд “Бахрейн-2025” Азийн залуучуудын наадам, “Милан Кортина -2026” Өвлийн олимпын наадам, “Айчи Нагояа-2026” Азийн наадамд оролцох Монгол Улсын баг тамирчдыг дэмжин хамтран ажиллахаар боллоо. Энэхүү хамтын ажиллагаагаар эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, энх тайван, эв нэгдэл, улс орноо таниулах, олимпын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулж байна.



AMCHAM CSR AWARDS 2025 – SUSTAINABILITY

Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам)-аас нийгмийн хариуцлагын болон тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн шилдгийг шалгаруулдаг “AmCham CSR Award” арга хэмжээнээс “Маргаашийн Ой” төслөөрөө Тогтвортой Хөгжил төрөлд шалгарлаа. Энэхүү төслийг БНСУ-ын “Имарт” компанийн санаачилга, санхүүжилтээр “Future Forest”, “Азийн ойн хамтын ажиллагааны байгууллага” (AFoCo), БНСУ-ын “Ойн алба” (Korea Forest Service), Монгол Солонгосын “Ногоон хэрэм” төслийн III шат зэрэг олон улсын байгууллагууд, мөн “Скай Хайпермаркет” ХХК-ийн ажилтнууд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 5 жилийн хугацаанд 4.4 га талбайд голын эргийн ногоон байгууламжийг нөхөн сэргээж цаашид иргэд цэвэр агаарт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхийн зэрэгцээ экологийн мэдлэгээ нэмэгдүүлэх боломжтой цэцэрлэгт хүрээлэн байгуулах ач холбогдолтой юм.





8 ХАВСРАЛТ

2025 оны онцлох амжилтууд
Гэрчилгээ, баталгаажуулалт
Гишүүнчлэл болон шагнал
Гишүүн болон “Санамж бичиг” байгуулсан байгууллагууд

2025 ОНЫ ОНЦЛОХ АМЖИЛТУУД



“ИМАРТ ТЭНГЭР” 6 ДАХЬ САЛБАРАА АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА

2025 онд зургаа дахь салбар болох “Имарт Тэнгэр” салбарыг ашиглалтад орууллаа. Тус салбар нь Баянзүрх дүүргийн иргэд болон зүүн чиглэлийн орон нутгийн зорчигчдод өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлж байна. Имарт Тэнгэр салбар нь:

- 2,470 м² худалдааны талбай, 11,873 м² зорчигч үйлчилгээний танхимтай
- 1,100 хүртэлх үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай
- Такси, автобус, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэх мэт нийт 200 машины ил болон дулаан зогсоолтой.



МОНГОЛ УЛСЫН “ТОП-100” ААН-ИЙН НЭГЭЭР ШАЛГАРЛАА

Тайлант онд Монгол Улсын “ТОП-100” ААН-ийн 22-т эрэмбэлэгдэж амжилтаа ахиуллаа. Скай Хайпермаркет ХХК нь дараах үзүүлэлттэйгээр “ТОП-100” ААН байгууллагаар дахин шалгарч амжилтаа бататгалаа:

- Борлуулалтын орлогын эрэмбээр – 30 -р байр
- Төлсөн татварын дүнгийн эрэмбээр – 45 -р байр
- Хөрөнгийн эрэмбээр – 33-р байр
- Ашгийн хэмжээний эрэмбээр – 52 -р байр
- Даатгуулагчийн тооны эрэмбээр – 13-р байр



“ШИЛДЭГ ХУДАЛДААНЫ ЭНТЕРПРЕНЁР” ШАГНАЛЫН ЭЗЭН БОЛЛОО

2025 онд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй оны онцлох аж ахуй нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгчдийг шалгаруулан өргөмжилдөг “ENTREPRENEUR-2025” шагнал гардуулах ёслолын 28 дахь удаагийн арга хэмжээнээс Имартын хамт олон Шилдэг Худалдааны Энтерпренёр шагналыг хүртлээ.

ГЭРЧИЛГЭЭ, БАТАЛГААЖУУЛАЛТ



CERTIFICATE
Гэрчилгээ

№: MC 11/OH&S 085 24

SKY HYPERMARKET LLC
СКАЙ ХАЙПЕРМАРКЕТ ХХК

Head office: 6th floor, Emart Chinggis branch, 12th Khoroolol, 3rd Khoroo, Bayanzurkh District, 13381, Ulaanbaatar, Mongolia
(Branch locations included in the scope are listed in the annex)

Тев оффис: *Монгол улс, Улаанбаатар хот, 13381, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 12-р хороолол, Имарт Чингис салбарын 6 давхар*
(Хамрах хүрээнд багтсан салбарын байршлыг хавсралтад тусгасан)

has been assessed and found to meet the requirements
стандартын шаардлагын дагуу нэгтгүүлснийг баталгаажуулан гэрчилгээ олгов.

ISO 45001:2018

Certification scope
Хамрах хүрээ

Food and non-food products retail and service
Хүнс ба хүнс бус барааны жижиглэн худалдаа, үйлчилгээ

First issued date: **2024.10.18** *Анх олгосон огноо*
Issued date: **2024.10.18** *Олгосон огноо*
Valid until: **2027.10.17** *Хүчинтэй хугацаа*

MONCERTF LLC Unit 1505, Hoimor office, 15th floor, Altain street, 281, 9th khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar 14182, Mongolia.
Tel: 70115522, E-mail: info@moncert@gmail.com
МОНСЕРТФ ХХК, Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, Алтайн гудамж 281, Хоймор офис, 15 давхар, 1505 тоот.

ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй менежментийн тогтолцооны гэрчилгээ



CERTIFICATE
Гэрчилгээ

№: MC 11/EMS 072 24

SKY HYPERMARKET LLC
СКАЙ ХАЙПЕРМАРКЕТ ХХК

Head office: 6th floor, Emart Chinggis branch, 12th Khoroolol, 3rd Khoroo, Bayanzurkh District, 13381, Ulaanbaatar, Mongolia
(Branch locations included in the scope are listed in the annex)

Тев оффис: *Монгол улс, Улаанбаатар хот, 13381, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 12-р хороолол, Имарт Чингис салбарын 6 давхар*
(Хамрах хүрээнд багтсан салбарын байршлыг хавсралтад тусгасан)

has been assessed and found to meet the requirements
стандартын шаардлагын дагуу нэгтгүүлснийг баталгаажуулан гэрчилгээ олгов.

ISO 14001:2015


Certification scope
Хамрах хүрээ

Food and non-food products retail and service
Хүнс ба хүнс бус барааны жижиглэн худалдаа, үйлчилгээ

First issued date: **2024.10.18** *Анх олгосон огноо*
Issued date: **2024.10.18** *Олгосон огноо*
Valid until: **2027.10.17** *Хүчинтэй хугацаа*

MONCERTF LLC Unit 1505, Hoimor office, 15th floor, Altain street, 281, 9th khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar 14182, Mongolia.
Tel: 70115522, E-mail: info@moncert@gmail.com
МОНСЕРТФ ХХК, Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, Алтайн гудамж 281, Хоймор офис, 15 давхар, 1505 тоот.

ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцооны гэрчилгээ



GI-26-E395-01-00

Verification Opinion Statement

GHG Emissions Verification — Emart Mongolia Branches

Verification Target
Korean Foundation for Quality (hereinafter 'KFQ') has conducted an independent verification of Scope 1, 2 Greenhouse Gas Emissions (hereinafter 'GHG emissions') for Emart Mongolia Branches Sky Hypermarket LLC (EMART Inc. Mongolia) (hereinafter 'Company') for 2025. KFQ is responsible for providing an assurance statement on the GHG emissions based on the verification scope and criteria described below, while the responsibility for the claims made regarding the GHG emissions rests with the company.

Verification Purpose
The purpose is to provide an independent verification opinion on the company's voluntary GHG emissions inventories.

Verification Scope
KFQ's verification scope covered facilities and emission sources under the operational control and organizational boundary of the company during 2025.

Verification Criteria
The verification was carried out at the request of the company using:
- ISO 14064-1:2018, ISO14064-3:2019
- 2006 IPCC Guidelines for National Greenhouse Gas Inventories
- Rule for emission reporting and certification of greenhouse gas emission trading Scheme (Notification No. 2025-64 of Ministry of Environment)

Verification Approach
The verification has been conducted in accordance with the verification principles and standards of the 'ISO14064-3:2019' under the limited verification level. The verification shall contain the potential inherent limitation in the process of application of the verification criteria and methodology.

Conclusion
Based on the criteria and guidelines stated above, KFQ's verification opinion is as follows.
1) GHG emissions Company were properly calculated according to the verification standards.
2) The data and information used in calculating the GHG emissions were appropriate, reasonable, and no significant errors or omissions could affect verification statement were not found. The materiality assessment result of GHG emissions has met the agreed-upon criterion of less than 5%.
3) Accordingly, KFQ provides a verification opinion that is "Unmodified".

Unit : tCO_2eq

Scope 1	Scope 2	Total
381.056	27,989.758	28,371

* Because total emissions from each site are rounded, the company's total emissions may differ from the actual values by ±1 tCO_2eq.
* The emissions are included in Emart's Scope 3 Category 14 (Franchises).

June 17th, 2026

Ji Young Song
CEO Ji-Young Song
Korean Foundation for Quality

National Institute of Environmental Research

www.kfq.or.kr
Q Tower, 78 Samjeon-ro, Songpa-gu, Seoul, 05600, Republic of Korea

Хүлэмжийн хийн ялгаруулалтын баталгаажуулах тайлан

ГИШҮҮНЧЛЭЛ БОЛОН ШАГНАЛ

	ШАГНАЛ	ХУГАЦАА
Entrepreneur	Онцлох хөрөнгө оруулагч	2017
Entrepreneur	Дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжигч	2018
Entrepreneur	Худалдааны салбарын онцлох энтрепренер	2019
Entrepreneur	Сайн засаглалыг хэрэгжүүлэгч	2021
Entrepreneur	Ази, Номхон далайн орнуудын ХАҮТ-уудын Нэгдсэн Холбооны “Silver Mercury” шагнал	2023
Топ 100 ААН	98 дугаар байр	2016
	72 дугаар байр	2017
	63 дугаар байр	2018
	40 дүгээр байр	2020
	31 дүгээр байр	2021
	23 дугаар байр	2022
	24 дугаар байр	2023
	22 дугаар байр	2024
	22 дугаар байр	2025
Олимпын Хороо	“Бөртэ Чоно” шилдэг ивээн тэтгэгч	2023
Голомт	Топ 10 картаар үйлчлүүлэгч байгууллага	2016
Mongolian property awards	Шилдэг худалдааны төв	2016
Bloomberg	Bloomberg awards	2022

	ШАГНАЛ	ХУГАЦАА
Management forum	Шилдэг CEO	2022
Анунгоо /20 жилийн ой/	Топ харилцагч	2019
Худалдааны салбарын шагнал	“Мөнгөн богц”	2018
Талархалын батламж	Нийслэлийн засаг дарга, Улаанбаатар хотын захирагч Сумъяабазар	2022
Худалдааны салбарын шагнал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй дэд бүтэц, орчныг бүрдүүлсэн байгууллага	2017
	Хүүхэд гэр бүлд ээлтэй ААНБ	2021
	Манлай хүний нөөцийн төсөл	2019
	Нийслэлийн оны шилдэг шимтгэл төлөгч ажил олгогч байгууллага	2017
ХҮДС-ийн Талархалын батламж	Уншлагын танхим иж бүрэн тохижуулж өгсөнд талархал	2019
	Монгол Чанар	2017
Хүндэт харилцагч	Оны шилдэг харилцагч	2017
	Оны хамгийн өндөр борлуулалтын өсөлттэй харилцагч	2018
	Оны шилдэг харилцагч	2018
	Шилдэг барилга байгууламж шалгаруулалт	2016
	Шилдэг худалдааны төв	2016
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	ШИЛДЭГ ХУДАЛДААНЫ ЭНТЕРПРЕНЁР	2025
Американ худалдааны танхим	AmCham CSR Awards - Sustainability	2025
Олимпын Хороо	“АЛТАН ТҮНШ” байгууллага	2025

ГИШҮҮН БОЛОН “САНАМЖ БИЧИГ” БАЙГУУЛСАН БАЙГУУЛЛАГУУД

БАЙГУУЛЛАГЫН НЭР
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Монголын Үндэсний Олимпын Хороо
Нийгмийн төлөө Хамтрагч байгууллагууд
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Нийслэлийн Онцгой байдлын газар
Монголын Таеквондогийн Холбоо
Монгол Улсын Их Сургууль
Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль
Голомт банк ХК
Худалдаа хөгжлийн банк ХК
“Бид Чадна” ТББ - хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний портал
Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв

emart

Монгол хүн Та 100 наслаг...

